Аюулгүй ажиллагааг эрхэмлэж, байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт технологи ашиглан ЦЭХ-ийг найдвартай, үр ашигтай дамжуулах нь бидний эрхэм зорилго мөн.

ДАМЖУУЛАХ Сүлжээ

2005 оноос эрхлэн гаргав.

ЦДҮС ТӨХК-ИЙН ХЭВЛЭЛ
www.transco.mn

№02 (160) 2024 оны 04 сар



# "ДАМЖУУЛАХЫН ЗАЛУУС" ТББ "МАЛЧДАД ТУСАЛЪЯ" ХАНДИВЫН АЯНЫГ ЗОХИОН БАЙГУУЛАВ



Улс орон даяар зудын гамшиг нүүрлэж малын тоо хорогдон, малчид шууранд уруудан төөрөх, харьяа сум, аймгийн төв рүүгээ холбоо барьж чадахгүй байгаа хүндрэлүүд гарсантай холбогдуулан "Малчдад тусалъя" сайн дурын хандивын аянг 2024.02.21-ний өдрөөс зарласан билээ.

Компанийн нийт ажилтнууд хандивын аянд сайхан сэтгэлийн угаас идэвхтэй оролцож нийт бэлэн мөнгөөр 200.000 /хоёр зуун мянган/ төгрөг, дансаар 12.712.222 /арван хоёр сая долоон зуун арван хоёр мянга хоёр зуун хорин хоёр/ төгрөг цугласныг компанийн Ерөнхий инженер Б.Эрхэмзаяа, "Дамжуулахын залуус" ТББ-ын тэргүүн Д.Төмөр-Очир, Нарийн бичиг Б.Баярмаа нар залуучуудаа төлөөлөн 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдөр Онцгой байдлын ерөнхий газарт хүлээлгэн өгч тус аяныг дэмжлээ.

Онцгой байдлын ерөнхий газар цугласан хандивыг үр ашигтай зарцуулах, хандивын эздэд үр өгөөжийг хүртээхээр хэрэгжүүлж буй ажлаа танилцуулаад, манай байгууллагын хамт олонд талархал гардуулж, ажлын амжилт хүслээ.

## ЦАХИЛГААН ХЭМЖЛИЙН ЛАБОРАТОРИ ИТГЭМЖЛЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ ГАРДЛАА

**"MNS IEC-17025:2018 Лаборатори итгэмжлэлийн үндэсний тогтолцоо"** стандартын дагуу Монгол Улсын зөвлөх инженер О.Өлзийхишигийн нэрэмжит Цахилгаан хэмжлийн лаборатори итгэмжлэлийн гэрчилгээг 2024 оны 05 сарын 03-ны өдөр гардан авлаа. Ингэснээр эрчим хүчний системд итгэмжлэгдсэн анхдагч лаборатори болж байгаа юм.





НҮҮР-3
КОМПАНИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ СПОРТЫН 5 ТӨРӨЛТ ТЭМЦЭЭН БОЛЛОО

НҮҮР-5
УЛААНБААТАР САЛБАР

НҮҮР-7
ХАНГАЙН БҮСИЙН САЛБАР

НҮҮР-9
ГОВИЙН БҮСИЙН САЛБАР

НҮҮР-11
ЯПОНЫ ЖАЙКА ОУХАБ-ЫН ЭХС-Т ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ЯПОН УЛСАД 33 АЖИЛТАН СУРГАЛТАД ХАМРАГДАВ

# КОМПАНИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ СПОРТЫН 5 ТӨРӨЛТ ТЭМЦЭЭН БОЛЛОО



"Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" ТӨХК-ийн үйлдвэрчний эвлэлийн хорооны нэрэмжит 5 төрөлт "Багануур спорт наадам-2024" тэмцээн 3 дугаар сарын 13, 14-ний өдрүүдэд Багануур дүүргийн "Уурхайчин" спорт цогцолборт амжилттай болж өндөрлөлөө.

Тус тэмцээнд төв удирдлага болон 5 салбарын төлөөлөл 200 гаруй инженер, техникийн ажилтан, албан хаагч нар авхаалж самбаа, хурд хүчээ сорин өрсөлдсөнөөс Улаанбаатар салбар багийн дүнгээр хошуучилж, шилжин явах цом гардсан бол дэд байрыг Зүүн-Өмнөд бүсийн салбар эзэлж, Төв удирдлага удаалсан.

**Сагсан бөмбөгийн эрэгтэй ангилалд**

- Тэргүүн байрыг Зүүн-Өмнөд бүсийн салбарын баг тамирчид
- Дэд байрыг Улаанбаатар салбарын баг тамирчид
- Гутгаар байрыг Төвийн бүсийн салбарын баг тамирчид

**Сагсан бөмбөгийн эмэгтэй ангилалд**

- Тэргүүн байрыг Зүүн-Өмнөд бүсийн салбарын баг тамирчид
- Дэд байрыг Улаанбаатар салбарын баг тамирчид
- Гутгаар байрыг Төвийн бүсийн салбарын баг тамирчид

**Воллейболын эрэгтэй ангилалд**

- Тэргүүн байрыг Улаанбаатар салбарын баг тамирчид
- Дэд байрыг Говийн бүсийн салбарын баг тамирчид
- Гутгаар байрыг Зүүн-Өмнөд бүсийн салбарын баг тамирчид

**Воллейболын эмэгтэй ангилалд**

- Тэргүүн байрыг Зүүн-Өмнөд бүсийн салбарын баг тамирчид
- Дэд байрыг Улаанбаатар салбарын баг тамирчид
- Гутгаар байрыг Говийн бүсийн салбарын баг тамирчид

**Шатрын төрөлд**

- Тэргүүн байрыг Хангайн бүсийн салбарын баг тамирчид
- Дэд байрыг Улаанбаатар салбарын баг тамирчид
- Гутгаар байрыг Төв удирдлага салбарын баг тамирчид

**Ширээний теннисний төрөлд**

- Тэргүүн байрыг Хангайн бүсийн салбарын баг тамирчид
- Дэд байрыг Говийн бүсийн салбарын баг тамирчид
- Гутгаар байрыг Төвийн бүсийн салбарын баг тамирчид



*Сагсан бөмбөгийн эрэгтэй төрөлд нэгдүгээр байр эзэлсэн Б.Пүрэвсүрэн ахлагчтай ЗӨБС-ын баг тамирчид*



*Сагсан бөмбөгийн эрэгтэй, эмэгтэй шилдэг тамирчинаар ЗӨБС-ын Б.Болдбаатар, Д.Отгонцэцэг нар шалгарав.*



*Сагсан бөмбөгийн эрэгтэй төрөлд хоёрдугаар байр эзэлсэн Б.Нэмэхбаяр ахлагчтай УБС-ын баг тамирчид*



*Сагсан бөмбөгийн эмэгтэй төрөлд нэгдүгээр байр эзэлсэн ЗӨБС-ын баг тамирчид*



*Сагсан бөмбөгийн эрэгтэй төрөлд гуравдугаар байр эзэлсэн ТБС-ын баг тамирчид*



*Сагсан бөмбөгийн эмэгтэй төрөлд хоёрдугаар байр эзэлсэн УБС-ын баг тамирчид*

**Дартсын төрөлд**

- Тэргүүн байрыг Улаанбаатар салбарын баг тамирчид
- Дэд байрыг Зүүн-Өмнөд бүсийн салбарын баг тамирчид
- Гутгаар байрыг Төв удирдлагын баг тамирчид тус тус эзэлсэн юм.

Мөн ахмадуудын дунд  биллъярд, теннисийн тэмцээн явагдаж 20 гаруй тамирчин оролцоноос  биллъярдын тэмцээний төрөлд Зүүн-Өмнөд бүсийн салбарын ахмад ажилтан Т.Ганбаатар дэд байр, Төв удирдлагаас ахмад ажилтан Э.Ганпүрэв тэргүүн, Теннисийн төрөлд Зүүн-Өмнөд бүсийн салбарын ахмад ажилтан Б.Пүрвээ дэд байр, Хангайн бүсийн салбарын ахмад ажилтан Д.Дашням тэргүүн байрт шалгарсан юм.

Энэхүү уламжлалт тэмцээний сагсан бөмбөгийн эрэгтэй шилдэг тоглогчоор Зүүн-Өмнөд бүсийн салбарын Б.Болдбаатар, эмэгтэй шилдэг тоглогчоор Зүүн-Өмнөд бүсийн салбарын Д.Отгонцэцэг, волейболын шилдэг эрэгтэй тоглогчоор Улаанбаатар салбарын Н.Мөнхцогт, эмэгтэй шилдэг тоглогчоор Зүүн-Өмнөд бүсийн салбарын Э.Энхмаа нар шалгарч баг тамирчидыг манлайлав.



Сагсан бөмбөгийн эмэгтэй төрөлд гуравдугаар байр эзэлсэн ТБС-ын баг тамирчид



Гар бөмбөгийн эрэгтэй төрөлд нэгдүгээр байр эзэлсэн Н.Мөнхцогт ахлагчтай УБС-ын баг тамирчид



Гар бөмбөгийн эрэгтэй төрөлд хоёрдугаар байр эзэлсэн Н.Бямбадорж ахлагчтай ГБС-ын баг тамирчид



Гар бөмбөгийн эрэгтэй төрөлд гуравдугаар байр эзэлсэн Ж.Түвшинтөгс ахлагчтай ЗӨБС-ын баг тамирчид



Гар бөмбөгийн эмэгтэй төрөлд I байр эзэлсэн ЗӨБС-ны баг тамирчид



Гар бөмбөгийн эмэгтэй төрөлд II байр УБС-ын баг тамирчид



Гар бөмбөгийн эмэгтэй төрөлд III байр эзэлсэн ГБС-ын баг тамирчид



Гар бөмбөгийн  эрэгтэй, эмэгтэй шилдэг тамирчинаар ЗӨБС-ын Э.Энхмаа, УБС-ын Н.Мөнхцогт нар шалгарав.



Шатрын төрөлд I байр Төв удирдлагын баг тамирчид, II байр УБС-ын баг тамирчид, III байр ХБС-ын баг тамирчид



Ширээний теннисний төрөлд I байр ХБС-ны баг тамирчид, II байр ГБС-ын баг тамирчид, III байр ТБС-ын баг тамирчид



Дартсын төрөлд нэгдүгээр байр эзэлсэн Төв удирдлагын баг тамирчид



Дартсын төрөлд хоёрдугаар байр эзэлсэн Б.Түвшинбаяр ахлагчтай ЗӨБС-ын баг тамирчид



Дартсын төрөлд гуравдугаар байр эзэлсэн УБС-ын баг тамирчид



Ахмадуудын дунд явуулсан биллъярдын тэмцээний төрөлд дэд байрт шалгарсан Зүүн-Өмнөд бүсийн салбарын ахмад ажилтан Т.Ганбаатар



Ахмадуудын дунд явуулсан ширээний теннисний төрөлд нэгдүгээр байр эзэлсэн Хангайн бүсийн салбарын ахмад ажилтан Д.Дашням



Ахмадуудын дунд явуулсан ширээний теннисний төрөлд дэд байр эзэлсэн Зүүн-Өмнөд бүсийн салбарын ахмад ажилтан Б.Пүрвээ



Ахмадуудын дунд явуулсан биллъярдын төрөлд тэргүүн байр эзэлсэн Төв удирдлагын ахмад ажилтан Э.Ганпүрэв

ТӨВ УДИРДЛАГА

# "ХАБЭА, ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬ БОЛОН ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭН САЙН МЭДЭХ ВЭ" СЭДЭВТ УР ЧАДВАРЫН ТЭМЦЭЭН



Монгол Улсын хэмжээнд жил бүрийн дөрөвдүгээр сарыг Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сар болгон зарлаж, хөдөлмөрийн аюулгүй байдлын талаар өргөн цар хүрээтэй арга хэмжээнүүд зохион байгуулагддаг билээ.

Эрчим хүчний яамнаас өгсөн чиглэлийн дагуу энэхүү сарын аяны хүрээнд "ХАБЭА-н тухай хууль", "Хөдөлмөрийн тухай хууль", "Галын аюулгүй байдлын тухай хууль"-ийг хэн сайн мэдэх вэ сэдэвт хуулийн тэмцээнийг Хяналт мониторингийн хэлтэс төв удирдлагын Үйлдвэрчний эвлэлийн хороотой хамтран төв удирдлагын ажилтнуудын дунд 2024 оны дөрөвдүгээр 18-ны өдөр амжилттай зохион байгуулав.

Ажилтнуудын хууль, дүрмийн мэдлэгийг дээшлүүлэх, багууд харилцан хоорондоо ХАБЭА-н арга туршлага солилцох зорилготой энэхүү тэмцээнд нийт 9 баг "ХАБЭА-н тухай хууль", "Хөдөлмөрийн тухай хууль", "Галын аюулгүй байдлын тухай хууль", "Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм"-ээс боловсруулсан тест бөглөх, багийн дунд болон багийн ахлагч нарын дундах асуултад







хариулт, Ажлын байран дахь аюул, эрсдэл сэдэвт зурагт ажилбар, ХАБЭА-н талаар тулгамдаж буй асуудал сэдвийн хүрээнд гэрийн даалгавар бэлтгэн ирж оролцсон юм.

Тэмцээний нийлбэр дүнгээр С.Ариунбат ахлагчтай Засвар зохицуулалт, төслийн хэлтсийн "Зөв зааварчилгаа таныг хамгаална" баг 48 оноогоор 1-р байр, Б.Лут-Эрдэнэ ахлагчтай Реле хамгаалалт, автоматик, хэмжилт, туршилтын хэлтсийн "Protection" баг 47,2 оноогоор 2-р байр, Э.Болор-Эрдэнэ ахлагчтай Бизнес төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн "The ONE" баг 46,1 оноогоор 3-р байрт шалгарч өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдсан.

Тэмцээний өрөнхий шүүгч компанийн Ерөнхий инженер Б.Эрхэмзаяа ажилтнуудын хууль эрх зүйн талаарх ойлголт мэдлэг сайн байгаад сэтгэл хангалуун буйгаа илэрхийлэхийн ялдамд цаашид энэхүү тэмцээнийг жил бүр уламжлал болгон зохион байгуулах нь зүйтэй хэмээн онцолсон юм.

Тэмцээнийг амжилттай зохион байгуулсан баг болон тэмцээнд оролцсон бүх ажилтнуудаа талархал илэрхийлж, ажлын амжилт хүсэн ерөөе.

***Хяналт мониторингийн хэлтэс***

# НИЙТ АЖИЛТНЫ ХАБЭА-Н СУРГАЛТ











**ХАБЭА**-н тухай хуулийн 17.4, 27.3.4 дахь заалт, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны сургалт явуулах үндсэн дүрэм MNS 4969:2000 стандарт, ХНХ-н сайдын 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/173 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт явуулах болон шалгалт авах журам"-ын 2.2 дахь заалтын дагуу Хяналт мониторингийн хэлтэс "Обзерв консалтинг", Хүний аюулгүй байдлын академитай хамтран төв удирдлагын ажилтнуудад зориулсан "НИЙТ АЖИЛТНЫ ХАБЭА-Н СУРГАЛТ"-ыг 2024 оны 04-р сарын 25-ны өдөр зохион байгууллаа. Энэхүү сургалтанд төв удирдлагын 70 орчим ажилтан хамрагдсан бөгөөд сургалтыг "Обзерв консалтинг" компанийн зөвлөх, сургагч багш н.Тунгалаг, ХАБ академийн сургагч багш, ХАБЭА-н удирдлагын докторант О.Одцэрэн, сургагч багш Ч.Лхагвасүрэн нар явуулав.

Сургалтыг танхимаар зохион байгуулсан бөгөөд сургалтад оролцсон ажилтнуудыг багт хуваан ажлын байрны аюулын дүн шинжилгээ сэдвээр даалгавар хийлгэж, ажилтнуудад мэдлэг, чадвар олгосон үр дүнтэй сургалт болж өнгөрлөө.

***Хяналт мониторингийн хэлтэс***

## ХАБЭА ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

**Олон улсын стандарт нэвтрүүлэх ажлыг эхлүүлэв**

Компанийн гүйцэтгэх захирлын 2024 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн А/20 дугаар тушаалаар Улаанбаатар салбарт “Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцооны ISO45001:2018” стандартыг нэвтрүүлэх багийн гишүүд томилогдов. Тус стандартыг нэвтрүүлэх арга зүйн зөвлөгөө өгөх, зөвлөх үйлчилгээ үзүүлж буй “Обзерв консалтинг” ХХК-ийн зөвлөх ажилтнууд Улаанбаатар салбарт ажиллаж, өөрүүгийн шинжилгээ хийж, тайланг танилцуулсан. Мөн багийн гишүүд стандарт нэвтрүүлэх чиглэлээр сургалтад хамрагдаж, зөрүүтэй байгаа ажлуудад үүрэг даалгавар авч, стандартад нийцүүлэх чиглэлээр ажлуудыг шат дараалалтай гүйцэтгэж эхэллээ.



**“Хөдөлмөрийн аюулгүй байдлын өдөр”-ийг зохион байгуулав**

Улаанбаатар салбарын хэмжээнд сар бүрийн 2 дахь 7 хоногийн мягмар гаригт зохион байгуулдаг “Хөдөлмөрийн аюулгүй байдлын өдөр”-ийг 2024 оны 03 дугаар сарын 12, 04 дүгээр сарын 16-ны өдрүүдэд тус тус зохион байгуулж, ажилтнуудад танхим болон цахим хэлбэрээр хамрагдав. Тус өдрөөр сэрэмжлүүлэх мэдээлэл даалгавар №2, зэлжит бус зааварчилгаа танилцуулах, шинэ ажилтнуудад сургалт явуулах ажлыг зохион байгуулж, “ХЭМАБ”-н менежментийн тогтолцоо нэвтрүүлэх зөвлөх үйлчилгээ үзүүлж буй “Обзерв консалтинг” ХХК-ийн зөвлөх Ж.Дэлгэрцэцэг “Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцоо ISO45001:2018 нэвтрүүлэх” төслийн танилцуулга хийж, компанийн хэмжээнд 90/10 хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан “Хувь хүний хөгжил, ажлын байранд өөрийгөө хөгжүүлэх нь” сэдвээр сургагч багш Б.Төмөр-Очир нийт ажилтнуудад сургалт явуулав.



**Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн III шатны үзлэг зохион байгуулав**

Улаанбаатар салбарын ажлын хэсэг батлагдсан удирдамжийн дагуу нийт 14 ажлын байранд 2024 оны 1 дүгээр улирлын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн III шатны үзлэг, шалгалт явуулж, үзлэгт 145 ажилтан хамрагдаж, давхардсан тоогоор 24 үүрэг даалгаврыг тайлан хэлбэрээр холбогдох алба, хэсэгт танилцуулж, цаашид хийгдэх ажлын төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг нь хангуулж, гүйцэтгэлийг нь шалган ажиллаж байна.



**Гал, гамшгийн чиглэлээр хийсэн ажлууд**

Улаанбаатар салбарын даргын 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн А/05 дугаар тушаал, “Эрчим хүчний ажилтны дунд зохиох аюулгүй ажиллагааны үндсэн дүрэм”, “Галын аюулгүй байдлын тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангах зорилгоор ажлын байрны галын аюулгүй байдалд үзлэг хийх удирдамжийн дагуу салбарын 33 дэд станц, салбарын байранд үзлэг, шалгалт хийж, үзлэгээр илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Улаанбаатар салбарын ажилтнууд 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 16,00 цагт "Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуулилалт" хийв.



**Хамгаалалтын зурваст дэглэм сахиулах аяны хүрээнд**

Хамгаалалтын зурваст албан мэдэгдэл тараах аяны хүрээнд батлагдсан удирдамж, хуваарийн дагуу нийслэлийн 6 дүүргийн нутаг дэвсгэрээр дайран өнгөрч буй цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын хамгаалалтын зурваст 220 кВ-ын 2, 110 кВ-ын 10, 35 кВ-ын 2 шугамын трассын дагуу 291 аж ахуй нэгж, 691 айл өрх, нийт 933 албан мэдэгдэл хүргүүлсэн.



**“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн +3М" тэмцээн зохион байгуулав**

Компанийн гүйцэтгэх захирлын 2024 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 01/440 тоот удирдамжийн дагуу хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, хөдөлмөрийн тухай хууль, эрчим хүчний салбарын аюулгүй ажиллагаа, техник ашиглалтын дүрэм, үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэх дүрмийг сурталчлан таниулах, мэдлэгийг түгээх, мэдээлэл солилцох, хандлагыг өөрчлөн өдөр тутмын зөв дадал хэвшүүлэх, бүх нийтийн оролцоог хангах зорилгоор Улаанбаатар салбарт “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн +3М" тэмцээнийг 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр амжилттай зохион байгуулав. Тэмцээнд нийт 8 баг оролцож, салбарын дарга Д.Будхүү, компанийн ҮЭХ-ны дарга Ц.Мөнхбаатар, ХАБЭА, хяналтын ахлах инженер Н.Нямдаваа нар шүүж, их оноогоор системээр дүгнэв. Тэмцээний 1-р байранд Засварын албаны “Positive” баг, 2-р байранд Инженерийн албаны “Зөв” баг, 3-р байранд Ашиглалт, шуурхай үйлчилгээний албаны “Safety first” баг тус тус шалгарч, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулав.



**Ээлжит болон ээлжит бус сургалтууд**

2024 оны 04 дүгээр сарын 15-24-ний өдрийг дуусталх хугацаанд Зүүн-Өмнөд бүсийн салбарын Сургалтын төвд зохион байгуулагдах “Хуваарилах байгууламж, дэд станцын ээлжийн монтёрын чадамжийн гэрчилгээ олгох” сургалтад Ашиглалт, шуурхай үйлчилгээний албаны дэд станцын ээлжийн монтёр Ч.Далгэрсүрэн, С.Баттулга, Д.Батсүрэн, Ш.Оюун, Б.Нандинцэцэг, Б.Алтантуяа нарыг хамруулсан.

## АШИГЛАЛТЫН ТҮВШИН, НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР

Дэд станцын анхдагч тоноглолын 2024 оны төлөвлөгөөт их засварын ажил эхэлсэн. 03-р сарын 11-13-ны өдрийн хооронд 110/35/10 кВ-ын Налайх дэд станцын Т-1, Т-2 трансформаторын 10 кВ-ын оролтын тосон таслуур, 10 кВ-ын СХТТ, 10 кВ-ын ХТ-2, Г/Х-тай тэргэнцэр, Зах, Аврах, Туул, Тосгон, Шилний үйлдвэр, Туул гэсэн нэр бүхий 6 гарсан шугамын тосон таслуурт төлөвлөгөөт их засварын ажлыг хийж гүйцэтгэсэн.



110/10/6 кВ-ын Умард дэд станцын 10, 6 кВ-ын I, II секцийн нийт 51 ком ячейк, 110/35/10 кВ-ын Дарь-Эх дэд станцын Т-1,2 трансформатор, 10 кВ-ын ДХТ-1,2, Г/Х-тай тэргэнцэр, 149,150-р АШ-ын ШуС, 110 кВ-ын ХТ-1, 2, С.С-1, 2, Т-1, 2-н 110 кВ-ын ШинС, ГТ, ЭТ, 110/35/10 кВ-ын Сэлбэ дэд станцын Т-1, 2, 110/35 кВ-ын I, II СШ-н бүх тоноглол, 205,206,107,108,109,110,149,150, 110 кВ-ын Ярмаг-А, Б АШ-д урсгал засварын ажил хийж гүйцэтгэсэн.





110/10/6 кВ-ын Умард дэд станцын 10 кВ-ын II секцийн РП-49Б-н таслуурын тэргэнцэр урсгал засварын ажлын хүрээнд схем задрахгүй гацаатай байсныг шинээр сольж засварласан.




220/110 кВ-ын ИХБ-4-н 109-р АШ-ын ШуС-н шугам талын ГХ-ны хориг гэмтсэн тул хүчин буусан тоноглолоос 1 ком приводоор сольж суурилуулах, 110/10 кВ-ын Илчбаян дэд станцын Т-2-н 110 кВ-ын ШинС-н редуктор хагарсныг шинээр солих ажлыг гүйцэтгэж, гэмтэл устгасан.




110/35 кВ-ын ИХБ-3-н 110 кВ-ын Дундгол АШ-ын ШуС, ТойС, ГТ, ЭТ, 220/110 кВ-ын ИХБ-4 110 кВ-ын Гео, 109,110-р АШ-ын ШуС, ТойС, ГТ, ЭТ, 109,110-р АШ-ын ХТ, 110/10/10 кВ-ын Гео дэд станцын Т-2 трансформатор, 110 кВ-ын Дундгол АШ-ын ШуС, Гео АШ-ын ШуС, 110 кВ-ын С.С-1, 2-т ашиглалтын түвшин дээшлүүлэх ажил хийсэн.




Аянгын улирлын бэлтгэл ажлын хүрээнд 2024 оны 03-р сарын 18-22-ны өдрүүдэд 35 кВ-ын Холбоо-А,Б, 110 кВ-ын Гео, Дундгол, 103,104,111,112-р АШ-уудад түүвэрчлэн дээд үзлэг хийх, газардуулгын эсэргүүцэл хэмжих, гагнах, бариулах, тулгууруудын дугаарлалт сэргээх, аюулгүй ажиллагааны плакат суурилуулах, гэмтэлтэй хөндийрүүлэгч элемент солих, шувуу үргээгч чангалах, суурилуулах зэрэг ажлууд хийж гүйцэтгэсэн.




*Мэдээллийг бэлтгэсэн: УБС-ын ЗААА-ны ахлах бөгөөд дотоод ажил хариуцсан мэргэжилтэн Т.Аюуш*

# ТӨВИЙН БҮСИЙН САЛБАР

## ХАБЭА ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

Дэлхий нийтийн ХАБЭА-н сарын аяны хүрээнд мөн ЭХЯ-ны төрийн нарийн бичгийн даргаас ирсэн удирдамжийн дагуу ХАБЭА-н тэмцээнийг 2024.04.19-ний өдөр салбартаа амжилттай зохион байгуулсан. Тэмцээн нь мэндчилгээ, онолын мэдлэг, багийн ахлагчийн зурагт ажилбар, гэрийн даалгавар, илтгэл гэсэн хөтөлбөрийн дагуу ХАБЭА хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон ААД, ТАД, Үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэх дүрмийг сурталчлан таниулах, хандлагыг өөрчлөх, өдөр тутмын зөв дадал хэвшүүлэх, бүх нийтийн оролцоог хангах зорилготой.






1-р байр Д.Эрдэнэ-Очир ахлагчтай 7 БУРХАН баг

ХАБЭА тэмцээнд нийт 6 багийн 42 ажилтан хамрагдсан. Багууд удирдамжийн дагуу бэлтгэл сайн хангасан ба өрсөлдөөн энэ тэнцүү байлаа. Онолын мэдлэгийг багууд 70%-ийн дундажтай бөглөсөн ба мэндчилгээг ХАБЭА-н чиглэлээр уран сэтгэж чөлөөт үзүүлбэрээр гаргасан нь онцлог байв.



2-р байр Б.Баттөмөр ахлагчтай ЭРСДЭЛГҮЙ баг

Гэрийн даалгаварт салбарын хүрээнд хийсэн бусдад таниулан сурталчилсан бүтээлч ажлыг танилцуулсан. Илтгэл нь ажлын байрны сэтгэл ханамж, чадамжтай боловсон хүчин бэлтгэх, АМХ-ыг өргөнөөр ашиглах, хамгаалалтын зурвасын зай хэмжээг урьдчилан тогтоож таниулах, хүн бүр ХАБЭА ажилтан байх сэдвийг хөндсөн байлаа.



3-р байр Н.Гансүх ахлагчтай SAFETY баг



ТӨВИЙН БҮСИЙН САЛБАР

**Хамгаалалтын зурвасын аян ХАБЭА**



Хамгаалалтын зурвасын аяны хүрээнд салбартаа төлөвлөгөө гарган ажиллаж байна. Аяны хүрээнд

- Дархан-Уул аймгийн засаг даргад хамгаалалтын зурвасын захирамжийг шинэчлэх тухай албан бичиг
- Сэлэнгэ аймгийн засаг даргад аймгийн хэмжээнд зөрчилтэй айлуудын судалгаа, зөрчлийг бууруулахад хамтран ажиллах албан бичиг
- Сүхбаатар сумын засаг даргад зөрчилтэй айлуудын судалгаа, зөрчлийг бууруулахад хамтран ажиллах албан бичиг
- Сэлэнгэ аймгийн Ерөө сум, Бугант тосгонд хамгаалалтын зурвасын зөрчил, тэдгээрийг бууруулахад хамтран ажиллах албан бичиг
- Дархан-Уул аймаг болон Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын зөрчилтэй айл өрх, ААН-д мэдэгдэх хуудас зэргийг төлөвлөн гаргаж хүргүүллээ.



Салбарын харьяа 18 дэд станц тэдгээрийн 220/110кВ-ын гарсан шугамын төв суурин газарт ээлжит бус үзлэгийг зохион байгууллаа. Үзлэгийн үр дүнг үндэслэн Сэлэнгэ аймаг болон Дархан-Уул аймгийн хамгаалалтын зөрчилтэй ААН, айл өрхийн судалгааг шинэчлэн гаргаж дууссан.




Дархан, Сэлэнгэ аймгийн зөрчилтэй айл өрх ААН-д мэдэгдэх хуудсыг тараасан.

110кВ-ын Сүхбаатар АШ-ын тулгуур №292-320 тулгуурын трасс цэвэрлэх ажлыг 2024.04.01-10-ний хооронд хийж дуусгасан.

Хамгаалалтын зурвасын аюул эрсдэл, зай хэмжээг сурталчлан таниулах, холбоо барих утас зэргийг тусгасан шторкыг хийж орон нутгийн facebook болон цахим сайтад байршуулан ажиллаж байна.

## АШИГЛАЛТЫН ТҮВШИН, НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР

**Их засварын ажил**

110 кВ-ын Сүхбаатар агаарын шугамын тулгуур №292-314, 316-318 хүртэлх 24 пролет 4200м² талбайн ургаа мод болон трасс цэвэрлэх ИЗ-ын ажлыг Засварын албаны ахлах бөгөөд засварын инженер Б.Анхбаяр удирдан АГТ-ний дагуу 2024 оны 4 сарын 01-ний өдрөөс 4 сарын 11-ний өдрийн хооронд агаарын шугамын 15 хүний бүрэлдэхүүнтэй бригадтай бүрэн хийж гүйцэтгэсэн.




**А. Төлөвлөгөөт ажил:**

1. 110/6 кВ-ын Давхар, Бурхант дэд станцын анхдагч тоноглолын урсгал засварын ажил III/4-15 хооронд графикийн дагуу, 110/6 кВ-ын Үйлдвэр дэд станцын урсгал засварын ажил III/18-29 хооронд графикийн дагуу бүрэн хийгдсэн. 110/35/10 кВ-ын Баясгалант дэд станцын анхдагч тоноглолд ээлжит УЗ-ын ажил графикийн дагуу IV/8-17 хооронд 110/35/6 кВ-ын Зүүнхараа дэд станцын анхдагч тоноглолд ээлжит УЗ-н ажил графикийн дагуу хийгдсэн.





2. 110 кВ-ын Үйлдвэр А:Б.АШ-ын засварын ажлаар гэмтсэн утас засварлах, Дархан АШ-ын засварын ажлаар бор элементийг 96ш-ПС-70 шаазан элементээр солих, 113, Баясгалант АШ-ын засварын ажлыг АГТ-ний дагуу илэрсэн гэмтлүүдийг устгаж бүрэн хийж гүйцэтгэсэн. III/IV/14-26





3. Эрчим хүчний шугам сүлжээний хамгаалах зурвасыг сахиулах "Сарын аян"-ны ажлыг зохион байгуулан салбарын харьяа 220, 110 кВ-ын ЦДАШ, Дэд станцын хамгаалалтын зурваст 2024 оны 4 сарын 4-5-ны 110кВ-ын Дархан, Сүхбаатар, Ерөө шугамын дагуу судалгаа хийж Дархан суманд зөрчилтэй 16 айл өрх, 1 аж ахуйн нэгж, Сүхбаатар сумд зөрчилтэй 19 айл, 1 аж ахуйн нэгж газрууд судалгаанд хамрагдсан. Эдгээр газруудад компанийн зүгээс зөрчил арилгах, хашаагаа зайнд татах "МЭДЭГДЭЛ" хуудсыг тарааж, сурталчилгаа хийсэн.





**Б. Төлөвлөгөөт бус ажил болон гэмтэл устгалтын ажил**

1. 110 кВ-ын Сүхбаатар АШ-ын Т№21-н А-фазын элемент гярландаараа нэвт цохигдсоныг сольж, Давхарын салааны Т№2-н С-фазад тохогдсон төмөр утас, шувууны үүр авч, 110кВ-ын Орхон Агаарын шугамын Анкер Тулгуур №13 В фазд шлеф тасарсанг оруулга оруулж, 220кВ-ын 208-р АШ-ын Тулгуур №52-ын Афаз нэвт цохигдсоныг сольж гэмтэл устгалтын ажлыг хийж гүйцэтгэсэн.

**В. Агаарын шугамын эргүүл үзлэг**

1.110кВ-ын 114, 115, 116, Баясгалант, 220 кВ-ын 208-р АШ-ын нийт уртад ээлжит эргүүл үзлэг хийсэн. Үзлэгээр:116-р АШ-н Т№240-ын А,С-фазын шлейфний 1ш элемент нэвт цохигдсон, Т№238-н А-фазын 1ш элемент хагархай, 115-р АШ-н Т№248-н С-фазын 1 жийл, Т№78-н С-фазын 2 жийл, Т№48-н В-фазын 1 жийл, Т№29-н С-фазын 2 жийл тасархай, Т№236-н С-фазын 1ш элемент, Т№223-н А-фазын 1ш элемент, Т№168-н В-фазы 1ш элемент, Т№78-н В-фазын 1ш элемент нэвт цохигдсон, Шарын гол д/ст талд АТ№161-н С-фазы 1ш элемент хагархай, 208-р АШ-н Т№394-н С-фазын 1ш элемент, Т№389-н А-фазын 1ш элемент хагархай, Т№310-н 1 жийл, Т№266-н 2 жийл тасархай, Т№374,347,310 татуурганы тросс суларсан зэрэг гэмтэл зөрчилүүдийг засварын ажлын хугацаанд бүрэн устгасан.





**Ашиглалт шуурхай үйлчилгээ**

АШҮА-ны ажилтнууд 2024.04.02-нд ДСЦТС-ХК Шуурхай ажиллагааны ажилчидтай төлөвлөгөөний дагуу уулзалт хийсэн. Нийт 18 ажилтан оролцож. Уулзалтаар ТСК болон ЦДҮС-н Шуурхай ажиллагааны харьцааны заавриын мөрдөлт, хэрэглэгчийн ачааллын тооцоо, схемийн шинэчлэл, горим тооцоо, ША-явуулахад тулгамдаж буй асуудлууд сэдвээр ярилцаж, цаашид дүрэм заавриын мөрдөлтөнд анхаарч ажиллах тал дээр харилцан тохиролцож цаашид үе шаттайгаар хэрэгжүүлэх санал хүсэлтүүдийг хэлэлцэж шийдсэн.





*Мэдээллийг бэлтгэсэн: ТБС-ын ЗААА-ны бичиг хэрэг, архивч Д.Даваасүрэн*

## ХАБЭА ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

Салбарын хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр 03, 04 дүгээр саруудад дараах ажлууд хийгдлээ.

Салбарын хэмжээнд шинээр ажилд орсон болон ажлын байр өөрчлөгдсөн ажилтнуудаас дагалдан суралцах программын дагуу шалгалтын комисс тухай бүр шалгалт авч 3 ажилтныг жинхлүүлэн, 1 ажилтанд шинээр групп олгон, 3 ажилтны группийг ахиулсан байна.

**Наряд, шийдвэрээр хийгдсэн ажил:** Салбарын харьяа нийт 12 дэд станцын тоног төхөөрөмжүүд болон 110кВ, 220кВ-ын ЦДАШ-уудад нарядаар 76, шийдвэрээр 114 удаагийн ажил гүйцэтгэж, зөрчил дутагдалгүй ажиллалаа.

Ажил гүйцэтгэх бригадуудын нийт 590 ажилтанд тухайлсан зааварчилгааг өгч ажилласан байна.

**Дасгал, зааварчилгааны талаар:** Шинээр ажилд орсон 2 ажилтанд урьдчилсан зааварчилгаа, 4 ажилтанд ажлын байрны анхан шатны зааварчилгаа, 2731 ажилтанд өдөр тутмын зааварчилгаа, 246 ажилтанд сар бүрийн ээлжит зааварчилгаа, ээлжит бус зааварчилгаар 344 ажилтанд тус тус өгч ажилласан байна.

Салбарын алба, хэсэг, дэд станцууд дээр аваар эсэргүүцэх дасгал 9 удаа хийгдэж нийт 89 ажилтан, гал эсэргүүцэх дасгал 5 удаа хийгдэж нийт 46 ажилтан, осол эсэргүүцэх дасгал 6 удаа хийгдэж нийт 75 ажилтан тус тус хамрагдсан байна.

**ХАБЭА-н бүх шатны үзлэг:** Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн анхан шатны үзлэгийг давхардсан тоогоор 73 удаа хийж 126 зөрчил, II шатны үзлэгийг 24 удаа хийж 61 нэрийн зөрчил, III шатны үзлэгийг 19 зөрчлийг илрүүлэн нийтдээ 179 зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээг авч ажиллалаа.

**Бусад ажлаар:** Хамгаалалтын зурвасын дэглэм сахиулах сарын аяны хүрээнд хамгаалалтын зурвасын зөрчилтэй холбоотой Архангай, Булган, Хөвсгөл аймгийн засаг дарга нарт албан бичиг хүргүүлсэн. Мөн 21 аж ахуй нэгж, 27 иргэнд хамгаалалтын зурвасын талаар болон учирч болзошгүй эрсдэлийн талаар тайлбарлаж, гарын авлага өгсөн.





04-р сарын 05-ны өдөр МЭХГУУҮЭХ-с зохион байгуулсан ҮЭ-ийн идэвхтэн сонгуультнууд болон хөдөлмөр хамгааллын итгэмжлэгдсэн төлөөлөгч нарт зориулсан сургалтад ХАБЭА, хяналтын инженер Ж.Анхбаяр хамрагдсан.





## АШИГЛАЛТЫН ТҮВШИН, НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР

Салбарын 2023 оны ТЗБАХ-ын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан Эрдэнэт дэд станцын 220 кВ-ын 10 ком хуурай салгуур солих ажлыг "МОНХОРУС Интернэшнл" ХХК-ийн бригад 03 дугаар сарын 16-ны өдрөөс 04 дүгээр сарын 09-ний өдрийн хооронд гүйцэтгэж ашиглалтад оруулсан. Энэ ажлын хүрээнд РНДЗ маркийн хуурай салгуурыг БНХАУ-ын "Sieyuan-Electric" компанид үйлдвэрлэсэн GW4C-252 маркийн цахилгаан приводтой хуурай салгуураар солих ажил хийгдсэн.






2024 оны төлөвлөгөөт бус ТЗБАХ-ын ажлын хүрээнд Хархорин дэд станцад 03 дугаар сарын 11-ний өдрөөс 04 дүгээр сарын 19-ний өдрийн хооронд аваарын процесс бичигч "Парма" төхөөрөмжийг суурилуулж, ашиглалтад оруулсан. Уг төхөөрөмж нь нийт 128 аналог сигнал, 256 дискрет сигналын оролттой, ОХУ-д үйлдвэрлэгдсэн төхөөрөмж юм.





Азийн хөгжлийн банкны хөрөнгөөр Хөвсгөл аймгийн Мөрөн суманд баригдах 10 МВт-ын Нарны цахилгаан станцын төслийн хүрээнд Мөрөн дэд станцын 110 кВ-ын ИХБ-ыг өргөтгөх, Нарны станцын 1 хэлхээ ЦДАШ-ыг шинээр холбох, дэд станцын удирдлагын байрыг өргөтгөх ажил хийгдэж байна. Өнөөдрийн байдлаар өргөтгөлийн ажлын барилга угсралтын ажил 60,7%-тай байна.







**Гэмтэл устгалтаар хийгдсэн ажлууд**

- Хархорин дэд станц 110 кВ ХХ-А АШ таслуурын соронзон зүрхэвч гацсан гэмтлийг устгах
- Хархорин дэд станц СВГ-н В фазын 1-р модуль, 3-н фазын эсэргүүцэл, гадна хөргөлтийн системийн кабель тус тус солих




- 201-р АШ-н Т№239-н I фаз, Т№242-н III фазад нэвт цохигдсон элемент гирляндаар нь солих




- Эрдэнэт дэд станц Шулуутгагч №1-н 3-р модулийн гэмтэл устгах ажлууд хийгдсэн байна.

**Их засвараар хийгдсэн ажлууд**

- Эрдэнэт дэд станцын цахилгаан соронзон хоригийн их засварын ажлыг 03 дугаар сарын 25-наас 04 дүгээр сарын 05-ны өдрүүдэд хийж гүйцэтгэсэн




- Хархорин дэд станц 35кВ-н ХТ-1-н РХА-н их засварын ажлыг 04 дүгээр сарын 01-02-ны өдрүүдэд хийж гүйцэтгэсэн.




- Эрдэнэт дэд станц 110 кВ ГОК-А АШ-н таслуур, ШуС, ТойС-ын их засварын ажлыг 04 дүгээр сарын 01-02-ны өдрүүдэд хийж гүйцэтгэлээ.




*Мэдээллийг бэлтгэсэн: ХБС-ын ЗААА-ны сургалт, бүтээмжийн инженер Б.Ундрах*

# ЗҮҮН-ӨМНӨД БҮСИЙН САЛБАР

## ХАБЭА ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

2024 оны эхнээс урьдчилсан зааварчилгаанд шинээр ажилд орсон 12 ажилтан, сарын давтан зааварчилгаанд 653 ажилтан, ээлжит бус зааварчилгаанд 721 ажилтан, тухайлсан зааварчилгаанд 855 ажилтан, өдөр тутмын давтан зааварчилгаанд 7580 ажилтан давхардсан тоогоор тус тус хамрагдаж аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.

2024 оны "Хамгаалалтын зурвас"-ын дэглэм сахиулах аяны хүрээнд 9 ажилбар бүхий төлөвлөгөө гарган биелэлтийг ханган ажиллаж байна. 207-р АШ-ын хамгаалалтын зурвас зөрчөөд байгаа нүүрс тээврийн төмөр зам, хашаа барьсан "Хос хүлэг" ХХК, "УБ транс" ХХК, "Патрикен" ХХК болон Говьсүмбэр аймгийн засаг дарга, аймгийн ИТХ-ын дарга, Дорноговь аймгийн Замын-Үүд сумын засаг дарга, ИТХ-ын дарга нарт тус тус албан шаардлага хүргүүлж ажилласан. Нийт 8 албан шаардлага өгсөн байна.



110/10 кВ-н Замын-Үүд дэд станцын ИХБ-ийн зүүн талаар хамгаалалтын зурвас дотор нүүрс, ачаа тээврийн үйл ажиллагаа явуулж байгаа зөрчлийг арилгуулахаар төлөвлөлт хийж албан шаардлага хүргүүлсэн.

2024 оны 03 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн салбарын хэмжээнд нийт 12 дэд станцад шар усны үерээс урьдчилан сэргийлж ИХБ-д дахь цас, мөсийг цэвэрлэх, үерийн усны далан сувгуудад үзлэг хийх, барилга байгууламжийн дээвэр, тоноглолын шкаф, хайрцаг, тосны дренажи доторх цасыг цэвэрлэх ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

110/35/10 кВ-н Сайншанд, 110/6 кВ-н Төв, 110/10 кВ-н Баянмөнх, Замын-Үүд, Борхойн дэд станцууд үерийн далан шуудуу байхгүй боловч их хэмжээний бороо, шар усны үерт өртөх эрсдэл багатай гэж үзсэн байна.



Багануур дүүргийн хэмжээнд ХАБЭА-н сарын аяны нээлт "Уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөлд эрүүл, аюулгүй хөдөлмөр эрхэлцгээе" уриан дор 2024 оны 04 дүгээр сарын 09-нд зохион байгуулагдаж тус хуралд РХАХТА-ны дарга, Багануур дүүргийн ХАБЭА-н салбар зөвлөлийн гишүүн Ж.Чинбат, салбарын ХАБЭА-н инженер бөгөөд дотоод хяналтын ажилтан С.Зоригтбаатар нар оролцож ХАБЭА-н чиглэлээр сургалтад хамрагдан, ажилтнуудын эрүүл мэнд, бие эрхтний нөхөн сэргээх эмчилгээний тоног төхөөрөмж бараа бүтээгдэхүүний танилцуулга үзэж сонирхсон байна.



ХАБЭА сарын аяны хүрээнд салбарын ажилтнуудын үе мөч, харааны эрхтэн тогтолцоо, толгой хүзүүний шохойжилт, мэдрэл, нуруу, артерийн даралтын суурин аппарат гэх мэт эд эрхтнүүдийг нөхөн сэргээх эмчилгээний зориулалттай БНХАУ-ын үйлдвэрээс ирсэн "Pangao" брендийн цахилгаан соронзон болон хэт ягаан туяаны аппаратуудыг худалдан авах зардлыг салбарын ҮЭХ-с гарган авч эрүүл мэндийн ажилтан Р.Энхмаад хүлээлгэн өгөв.



Уг аппаратыг ажилд оруулснаар өдөрт 10-15 ажилтан тогтмол эмчилгээнд орж эрүүл мэндийн байдалдаа анхаарч байна. Одоогоор сэргээн засах эмчилгээнд 75 ажилтан давхардсан тоогоор хамрагдсан үзүүлэлт гарч байна.



Салбарын ХАБЭА-н ОТБЗ нь 2024 оны ХАБЭА-н аяны хүрээнд салбарын хэмжээнд 13 ажил зохион байгуулахаар төлөвлөгөө гарган батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

ХАБЭА-н сарын аяны хүрээнд зохион байгуулах томоохон ажлын нэг нь салбарын нийт ажилтнуудын дунд ХАБЭА-н чиглэлээр "Мэдлэг, ур чадвар" уралдааныг зохион байгуулахаар удирдамж гаргаж батлуулан Багануур, Чойр хэсэг, Өндөрхаан дэд станцуудад 04 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгуулахаар бэлтгэлийг хангаад байна.

2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр Замын-Үүд, Борхойн дэд станц, 04 дүгээр сарын 19-ний өдөр Сайншанд, Ширээт дэд станцын ажилтнууд ХАБЭА-н сарын аяны нэрэмжит уралдаан тэмцээнүүдийг АХА, Шог зураг, Наряд, сэлгэн залгалт төрлүүдээр зохион байгуулж амжилттай оролцсон багийн гишүүдийг салбарын ҮЭХ-ноос мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан байна.

## АШИГЛАЛТЫН ТҮВШИН, НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР

2024 оны 04 дүгээр сарын 22-ны байдлаар ТЗБАХ-ны 4 ажил төлөвлөснөөс 1 ажил хийгдэж 25 хувьтай, Их засварын 18 ажил төлөвлөснөөс 5 ажил хийгдэж 27 хувьтай, урсгал засварын 82 ажил төлөвлөснөөс 25 ажил хийгдэж 30 хувьтай, аянгын улирлын бэлтгэл ажлаар 28 ажил төлөвлөснөөс 8 ажил хийгдэж 28 хувьтай, ашиглалтын түвшин дээшлүүлэх ажлаар 121 ажил төлөвлөснөөс давхардсан тоогоор 45 ажил хийгдэж, гэмтэл устгах ажлаар өссөн дүнгээр 12 ажил тус тус хийсэн байна.

**Их засварын ажлаар:** 110/6 кВ-н Төв дэд станцад ЯчNo1,2,3,10 6 кВ-н тосон таслуур, 220/110/35/6 кВ-н Чойр дэд станцад ЯчNo2 6 кВ-н тосон таслуур, РХА хамт графикт хугацаанд нь хийж, гүйцэтгэлийг гаргасан.



**Урсгал засварын ажлаар:** 220/110/35 кВ-н Багануур болон Чойр дэд станцад AT-1,2 РХА туслах тоноглол, 220/110/35 кВ-н цэнэг шавхагч хэмжиж турших,110/6 кВ-н Хот, Төв дэд станцуудын Т-1,2 трын РХА шалгах тосны нэвчил зогсоох ОД, КЗ-н ажиллагаа шалгах 6 кВ-н гарсан шугамын РХА шалгах хэмжилт туршилт хийх, 110/35/10 кВ-н Айраг дэд станцын ЯчNo4, 21-н 10 кВ-н тосон таслууруудыг Хот дэд станцаас буусан вакуум таслуураар сольж, РХА-г бүрэн шинэчлэж тоноглолын найдвартай ажиллагааг хангасан. Мөн 110/35/10 кВ-н Сайншанд дэд станцад Т-1, 2 трансфоматорын РХА шалгах, тосны нэвчилт зогсоох, трансформаторыг будаж өнгө үзэмж сайжруулж зэрэг томоохон ажлууд хийгдсэн байна.



**Гэмтэл устгах ажлаар:** Сайншанд дэд станцад ЯчNo25 10 кВ-н Р-1-н хүчний кабель, ДХТ-2-н 10 кВ-н кабель шугамын гэмтэл устгах ажлыг богино хугацаанд засварлаж тоноглолын хэвийн найдвартай ажиллагаа хангав.



**Гэрээт ажлаар:** Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК болон "Монцемент Билдинг Материалс" ХХК-ийн хооронд байгуулсан ашиглалт засварын гэрээний дагуу Зүүн-Өмнөд Бүсийн салбарын РХАХТА, Засварын албаны бригадууд 110/35/10 кВ Сайншанд дэд станц, 110/6 кВ-н Булагт дэд станц болон Өргөн ДЦС-д ээлжит засвар тохируулгын ажлыг 2024 оны 03 дугаар сарын 20-22-ны өдрүүдэд зохион байгуулсан.

**Ашиглалтын түвшин дээшлүүлэх ажлаар**

Хэрэглэгчдийг тасралтгүй, найдвартай цахилгаан эрчим хүчээр хангах, гэнэтийн болзошгүй аваар, саатлаас урьдчилан сэргийлэх, урсгал засвар их засварын ажлын ээлжхүүн гаргах зорилгоор шугам тоноглолд инженер техникийн ажилтны үзлэгийг график төлөвлөгөөний дагуу 2024 оны 04 дүгээр сарын 05-17 ны өдрийн хооронд салбарын харьяа 220,110 кВ ЦДАШ-нд ээлжит үзлэгийг зохион байгуулж хийлээ.

Үзлэгийг Инженерийн албаны дарга бөгөөд ашиглалтын инженер Б.Ганбаатар, засварын инженер Г.Алтангэрэл, Засварын албаны дарга Г.Болдхуяг жолооч Б.Алтангэрэл, Г.Эрдэнэбаатар нар хийж гүйцэтгэв.

ЦДАШ-ын үзлэгээр 416 гэмтэл илэрсэн бөгөөд тасралтанд шууд нөлөөлөх гэмтэл байхгүй байсан. Илэрсэн гэмтлийг устгах ажлыг төлөвлөгөөт их ба урсгал засварын ажлаар хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн.

**Салбарын сургалтын бааз дээр зохион байгуулагдсан "Чадамжийн гэрчилгээ" олгох сургалтууд:**

- ЦДҮС ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2024 оны 03-р сарын 15-ны өдрийн №А/24 тоот тушаалын дагуу "Хуваарилах байгууламж, дэд станцын тоноглолын ашиглалт, засварын монтёр"-ын чадамжийн гэрчилгээ олгох сургалт Зүүн-Өмнөд бүсийн салбарын сургалтын бааз дээр 2024 оны 03-р сарын 18-ны өдрөөс эхлэн 03-р сарын 27-ны өдрийг дуустал хугацаанд хөтөлбөр, хуваарийн дагуу зохион байгуулагдсан бөгөөд 5 салбарын нийт 10 ажилтан хамрагдсан.
- 2024 оны 03-р сарын 27-ны өдөр Зүүн-Өмнөд бүсийн салбарын АШҮА-ны ахлах бөгөөд диспетчер инженер М.Баяржаргал, сургалт бүтээмжийн инженер Б.Ариунжаргал нар үнэлгээ, баталгаажуулалтыг хариуцан зохион байгуулж ажилласан. "Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт"-ийн Үнэлгээ гэрчилгээжүүлэлт хариуцсан арга зүйч А.Номин-Эрдэнэ хөндлөнгийн хяналт тавьж ажилласан.
- Тус сургалтад хамрагдсан 10 суралцагчид хөндлөнгийн үнэлгээ, баталгаажуулалтын багт онол болон ур чадвар гэсэн 2 чиглэлээр шалгалтыг өгч хангалттай үнэлгээ авсан.



*Мэдээллийг бэлтгэсэн: ЗӨБС-ын ИА-ны мэдээллийн технологи, компьютерын инженер Б.Пүрэвсүрэн*

## ХАБЭА ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

Салбарын хэмжээнд 2024 оны 03 дугаар сард нарядаар 10, шийдвэрээр 32 ажил хийгдсэн. Наряд, шийдвэрээр ажил гүйцэтгэхэд ажлын аюулгүй байдлыг хариуцагчид болон бригадын бүрэлдэхүүнд онцгой анхаарал, шат шатны зааварчилгаа чанартай өгч, хяналт тавьж ажилласан.

Салбарын хэмжээнд 9 удаагийн дасгал зохион байгуулагдаж 127 ажилтан хамрагдсан, сарын давтан зааварчилгаа 1128 хүн, тухайлсан зааварчилгаа 127, ээлжит бус зааварчилгаа 311 хүнд өгч ажилласан байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн анхан шатны үзлэгийг 299 удаа хийж 19 зөрчил, II шатны үзлэгийг 18 удаа хийж



33, III шатны үзлэгийг 1 удаа хийж 119 зөрчил илрүүлэн устгаж, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авч ажилласан. Галын аюулаас урьдчилан сэргийлэх үзлэгийг 134 удаа хийж ажилласан.

"Эерэг соёлыг зуршил болгоё" уриатай ХАБЭА-н сарын аяныг 04 дүгээр сард зохион байгуулахаар батлагдсан удирдамжийн дагуу 11 ажлыг хийхээр төлөвлөж хэрэгжүүлсэн. Уг сарын аяны хүрээнд салбарын ХАБЭА-н орон тооны бус зөвлөл УЭХ-той хамтран 38 ажилтанд Д витамин, 3 ажилтанд С витамин, 49 ажилтанд цайртай ашигтай бактери, 20 ажилтанд витамины нэгдэл өгсөн.

Захиргаа аж ахуйн алба болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн инженерүүд хамтран батлагдсан удирдамжийн дагуу "Нэн тэргүүнд ХАБЭА" сэдэвт тэмцээнийг 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр зохион байгуулж нийт 7 багийн 56 ажилтан оролцож мэдлэг оюун ухаанаа уралдуулсан.

Тэмцээн үндсэн 4 хэсгээс бүрдсэн. Үүнд:

- Нэн тэргүүнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй сэдвээр мэндчилгээ дэвшүүлэх
- Нийт багийн дунд "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Галын аюулгүй байдлын тухай хууль, Эрчим хүчний ажилтнуудын дунд зохиох аюулгүй ажиллагааны дүрэм, Цахилгааны ААД, ТАД", онолын мэдлэг сорих 10 минутаар 15 тест ажиллах
- Осолд дөхсөн тохиолдол сэдвээр зурагт ажилбар, дотор нь 3 шаттайгаар зохион байгуулсан.
  - Аюулыг илрүүлж, эрсдэлийг тодорхойлох
  - Сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах
  - Зурагт хийгдэж байгаа ажилд тохируулан зааварчилгаа өгөх
- ХАБЭА-г сайжруулах шинэ санал санаачилга сэдвээр 3-5 минут илтгэл тавих



Тэмцээний шүүгчээр салбарын ерөнхий инженер О.Дөлгөөн, ХАБЭА-н хяналтын ахлах инженер С.Намжилцэрэн нар оролцож багуудын гүйцэтгэсэн даалгавар тус бүрд 0-5 оноо өгч их онооны системээр дүгнэж 3 байр шалгаруулсан. Тэмцээний тэргүүн байранд АШҮА-ны дарга Ч.Сугиртогтох ахлагчтай "Хувийн хамгаалах хэрэгсэл" баг, дэд байранд инженерийн албаны засварын инженер Д.Батсуурь ахлагчтай "Гялс"баг, 3-р байранд засварын албаны шугамын засварын мастер Б.Лхагвасүрэн ахлагчтай "1 дүгээрт орох 1-р баг" тус тус шалгарч мөнгөн шагналаар шагнагдсан.

## АШИГЛАЛТЫН ТҮВШИН, НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР



Засварын албаны ахлах бөгөөд засварын инженер Д.Цэрэндамбаар ахлуулсан 10 хүнтэй бригад 2024 оны 04 дүгээр сарын 03-09-ний өдрүүдэд 220/110/35 кВ-н Мандал дэд станцын урсгал засварын ажил хийж гүйцэтгэсэн. Уг урсгал засварын ажлаар тоноглолуудын цэвэрлэгээ үйлчилгээ, боолтон холбоосуудын чангалгаа, фазын ялгаа сэргээх, трансформаторуудын тунгаагуур цэвэрлэх, тунгаагуурын тос солих ажлуудыг хийж гүйцэтгэсэн.



Засварын албаны шугамын засварын мастер Б.Лхагвасүрэнгээр ахлуулсан 7 хүний бүрэлдэхүүнтэй бригад 2 автомашинтай 2024 оны 04 дүгээр сарын 03,04,09,10-ны өдрүүдэд 215:216-р АШ-н урсгал засварын ажил хийж гүйцэтгэсэн. Тус ажлаар ГВН засах, хагарсан элемент солих ажил, сергоны гайк нөхөх хийх, очлуур хийх, аянгын троссны лочканы жийлт болон гүйсэн ГВН-г засах ажил, боолтон холбоосуудад үзлэг чангалгаа хийж, боолт дээр тэмдэглэгээ тавих ажил хийгдсэн.

Засварын албаны шугамын засварын мастер Б.Лхагвасүрэнгээр ахлуулсан 7 хүний бүрэлдэхүүнтэй бригад 2 машин механизмтай 2024 оны 04 дүгээр сарын 05-08-ны өдрүүдэд 217:218-р АШ-ын урсгал засварын ажил хийж гүйцэтгэв. Тус ажлаар аянгын троссны очлуурын тохироо хийх, аянгын троссны шлейф засварлах, авто замтай огтлолцсон хэсэгт анхааруулах бөмбөлөг хийх, хагарсан элемент солих, лочканы даравч боолтны гайк нөхөж хийх ажлууд хийгдсэн.

Засварын албаны ахлах бөгөөд засварын инженер Д.Цэрэндамбаар ахлуулсан 8 хүний бүрэлдэхүүнтэй бригад 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр 215:216-р АШ-н ТМ№182-28 хооронд түүвэрлэн нийт 15 цэгт 1 ба 3-р фазын элемент болон арматурын хэмжилт хийсэн. Мөн салхины хүч ихтэй 12 цэгт 12 тулгуурын боолт гайканд чангалгаа хийж, тэмдэг тавин дахин боолт гайк суларч байгаа эсэхийг үзэж шалгасан.



Өмнөговь аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар 110/35/10 кВ-н Даланзадгад дэд станцын Далан А,Б АШ-н тоноглол шинэчлэх ажлыг Засварын албаны дарга О.Хоринтаваны удирдлаган дор 7 хүний бүрэлдэхүүнтэй бригад хийж гүйцэтгэсэн. Уг ажлаар шинээр таслуур болон гүйдлийн трансформатор суурилуулсан.

Засварын албаны дарга О.Хоринтаван, засварын албаны ахлах бөгөөд засварын инженер Д.Цэрэндамба, инженерийн албаны дарга Ц.Эрдэнэчулуун, инженерийн албаны засварын инженер Д.Батсуурь нарын бүрэлдэхүүнтэй бригад салбарын харьяа 215:216, 217:218, 110 кВ-н Даланзадгад АШ-д ИТА нарын үзлэгийг зохион байгуулсан. Үзлэгийн үеэр урсгал засварын ээлжүүн тодорхойлох ажил гүйцэтгэсэн.



Клин энержи Ази ХХК-тай байгуулсан гэрээний дагуу 147:148-р АШ, 110/35 кВ-н Цэций СЦС-ийн урсгал засварын ажил хийж гүйцэтгэв. Уг ажлаар өвлийн их ачааллын дараах цэвэрлэгээ үйлчилгээ, тохироог хийж үзлэгээр илэрсэн гэмтлийг устгах ажлыг зохион байгуулав.

Салбарын ашиглалт шуурхай үйлчилгээний албаны ажилтнууд Эрдэнэс Тавантолгой нүүрс угаах үйлдвэрийг цахилгаан эрчим хүчээр хангах зориулалтаар баригдсан 110/35/10 кВ-н Сийрст дэд станцыг туршилтын хүчдэлд залгах ажлыг 2024 оны 03 дугаар сарын 07-ны өдөр хийж гүйцэтгэсэн.

Өмнөд бүсийн нутгаар 2024 оны 04 дүгээр сарын 13,14-ний өдрүүдэд хүчтэй шороон шуурга шуурсантай холбоотой дэд станцуудад үзлэг хийсэн. Үзлэгээр 220/110/35/10кВ Тавантолгой дэд станцын 10кВ-ын хаалттай хуваарилах байгууламжид нарийн элс шуурсан, шуурхай удирдлагын байрны дээврийн нурууны хучилт хуурсан гэмтэл илэрсэн. Дэд станцад шуурсан элсийг 04 дүгээр сарын 16,17-ны өдрүүдэд цэвэрлэж хэвийн болгосон. Тавантолгой дэд станц руу шуурах элсний нүүдлийг хаах зориулалтаар 2023 оны 05 дугаар сард хаягдал дугуй ашиглан хаалт хийсэн. Уг хаалт нь их хэмжээгээр шуурах элсний нүүдлийг саармагжуулахад нэмэр болсон, цаашид тус хаалтыг дахин өндөрлөх шаардлагатай байгаа нь шуурганы дараах байдлаар харагдаж байна.





**Сургалтын чиглэлээр хийгдсэн ажлууд:**

Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (JICA)-аас Монгол Улсад хэрэгжүүлж буй "Сэргээгдэх эрчим хүчний оролцоо ихтэй эрчим хүчний системийн тогтвортой байдлыг нэмэгдүүлэх, чадавхыг бэхжүүлэх төсөл"-ийн хүрээнд Япон улсад 2024 оны 02 дугаар сарын 25-ны өдрөөс 03 дугаар сарын 08-ны өдрийг дуустал хугацаанд зохион байгуулагдах "SWG-5 (ЦДАШ-ын засвар), SWG-6 (Дэд станцын засвар, оношлогоо) багуудын сургалтад засварын албаны шугамын засварын мастер Б.Лхагвасүрэн, РХА-н инженер Ц.Мөнхтөр нар хамрагдсан байна.



Зүүн өмнөд бүсийн салбарын сургалтын бааз дээр 2024 оны 03 дугаар сарын 18-ны өдрөөс 03 дугаар сарын 27-ны өдрийг дуустал хугацаанд зохион байгуулагдсан "Хуваарилах байгууламж дэд станцын тоноглолын засвар ашиглалтын монтёр"-ын сургалтад засварын албаны дэд станцын засварын монтёр Э.Мөнгөнсүх, Э.Энхмөнх нар хамрагдсан.



*Мэдээллийг бэлтгэсэн: ГБС-ын ЗААА-ны дарга Ц.Ганнягт*

# ЯПОНЫ ЖАЙКА ОУХАБ-ЫН ЭХС-Т ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ЯПОН УЛСАД 33 АЖИЛТАН СУРГАЛТАД ХАМРАГДАВ

**JICA олон улсын хамтын ажиллагааны хүрээнд Монгол Улсын сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэхийн тулд эрчим хүчний системийг тогтворжуулах төслийн SWG-4, SWG-6, SWG-3 ажлын хэсгийн тайлан**

Монгол Улсын сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэхийн тулд эрчим хүчний системийг тогтворжуулах төслийн хүрээнд Япон улсын JICA-Олон Улсын Хамтын Ажиллагааны байгууллагатай хамтран хийгдэж байгаа ажлуудын нэг болох SWG-4 буюу реле хамгаалалт, автоматикийн инженер, техникийн ажилтнуудыг чадваржуулах 4-р ажлын хэсэг нь ТУ-РХАХТХ-н Ахлах бөгөөд РХА инженер З.Батзориг, УБС-н РХАХТА-ны ахлах инженер Д.Төмөр-Очир, ЗӨБС-н РХАХТА-ны ахлах инженер Б.Мягмарсүрэн, ТБС-н РХАХТА-н РХА-н инженер Э.Амартүвшин, ДҮТ ТӨХХК-ийн лабораторын эрхлэгч Ц.Баяржаргал, лабораторын инженер Б.Баасанбаяр, АУЭХС-н ШЗА-н дарга Б.Пүрэвренчин, ББЭХС-н РХА-н инженер Б.Энхдулам болон сургагч багшаар Токиогийн Эрчим Хүчний Компанийн РХА-н инженер Сузуки Ясуюки, орчуулагч багш Н.Ганбилэг нарын бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна.

SWG-4 ажлын хэсгийн зорилго нь реле хамгаалалт, автоматикийн инженер, техникийн ажилтнуудыг чадваржуулах, реле хамгаалалтын гарын авлага, заавар, сургалтын материал бэлдэх, шинээр ажилд орж байгаа ажилчдыг сургах чадвартай сургагч багш нарыг бэлдэх юм. Энэхүү ажлын хүрээнд 2022 оны 12-р сараас эхлэн нийт 5 удаагийн сургалт зохион байгуулагдсанаас 4 удаа Улаанбаатар хотод танхимаар хичээллэсэн бөгөөд 3 дахь удаагийн сургалт нь 2023 оны 6-р сард Япон улсын Токиогийн Эрчим Хүчний Компанитай танилцах, туршлага солилцох чиглэлээр амжилттай зохион байгуулагдсан. Эдгээр сургалтуудад ажлын хэсэгт багтсан ИТА нар бүрэн хамрагдаж оролцсон.



Токиогийн Эрчим Хүчний Компани нь Токио орчмын бүс нутгийг хариуцан Япон улсын нийт эрчим хүчний 30%-ыг хангаж ажилладаг хамгийн том компани юм. Япон улсад зохион байгуулагдсан сургалтаар Токиогийн Эрчим Хүчний Компанийн үйл ажиллагаатай танилцах боломж олдсон ба сургалтын үеэр газар доорх дэд станц, усан цэнэгт батарей хуримтлуурын станц,устөрөгчийн цэнэгт дэд станц, RTDS, радио долгионоор шийдсэн алсын удирдлага, хамгаалалт, холбооны шийдлүүд гэх мэт олон дэвшилтэт технологи, тоног төхөөрөмжүүдийн ажиллагааг газар дээр нь очин танилцан, цаашид Монгол Улсын эрчим хүчний системд нэвтрүүлэх боломжуудыг судалж туршлага солилцсон юм.

Дадлага, сургалт хөтөлбөрийн дагуу 2024.02.25-2024.03.08-ны хооронд Япон улсын Токио хотын TIC /Tokyo International Center/ олон улсын төвд зохион байгуулагдсан тус сургалтаар

- ТЕРСО мэдээлэл холбоо
- Газар доорх дэд станц
- Трансформатор, реле, таслуурын үйлдвэр
- ТЕРСО сургалтын төв

эдгээр дэд станц төвүүдтэй танилцсан.







Реле хамгаалалт автоматикийн хувьд МУ-ын ЭХС-тэй харьцуулахад технологийн хувьд РХАБ нь тэр бүр нэвтэрсэн бус анхдагч тоноглол шиг харах судлах боломж хомс байлаа. Ашиглагч үйлдвэрлэгч хоёрын уялдаа манай ЭХС-ээс ялгарах гол хүчин зүйл нь байсан гэж хэлж болно. Тухайн РХАБ-ын тоноглолыг үйлдвэрлэгч нь ашиглалт тавил тохиргоо мэдээллийн сүлжээ зэргийн бүрэн хариуцдаг тул бидэнд ТЕРСО нарийн мэдээллийг өгөх нь боломжгүй юм.

Тиймээс бид сургалтыг энэ төсөл эхлэх үед сургагч багш Сузуки сантай ярилцаж дараах хөтөлбөрийг боловсруулж сургалт явуулж байна.

**SWG-4 ажлын хэсгийн онцлох ажлууд:**

1. Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн системийн 220,110кВ-н ЦДАШ-уудын шугамын эсэргүүцэл болон реле хамгаалалт, автоматикийн тавилын мэдээллийг багтаасан хамгаалалтын газрын зургийг Япон Токиогийн Эрчим Хүчний Компанид хэрэглэгддэг загварын дагуу шинээр зурж, цаашид системийн хэмжээнд ашиглахаар зорьж байна. Одоогоор нэгдсэн хамгаалалтын зураг зурагдаж, салбаруудын ЦДАШ-уудын мэдээллүүд орсон ба цаашид ТБНС-д холбогдсон системүүдийн мэдээллүүдийг оруулах ажил хийгдэж байна.



2. Бүх шатны ИТА нарыг сургаж бэлдэхэд шаардлагатай заавар, гарын авлага болгон ЦДАШ-н реле хамгаалалтын тавилыг тооцох аргачлал, стандарт, тавилын утга болон шалтгааныг дэлгэрэнгүй тайлбарласан "Реле хамгаалалтын тавил тохируулах заавар"-г бэлтгэж байна. Одоогийн байдлаар "Зайн хамгаалалтын тавил тохируулах заавар"-ыг бэлтгэн дуусгаж хянах ажил хийгдэж байна.



3. ЦДАШ-н тасралт, гэмтлийн үеийн аваарын бичлэгийн параметрүүдийн шинж чанар, өөрчлөлтийн долгионы хэлбэрийг ашиглан дүн шинжилгээ хийж реле хамгаалалтын дүгнэлтийн протокол шинээр боловсруулах ажил хийгдэж байна. Эдгээр дүн шинжилгээнүүдийг сургалтын материал болгон ашиглан шинэ ИТА-уудыг тасралт, гэмтлийн үеийн дүн шинжилгээг зөв хийх чадвартай болгохоор зорьж байна.



4. ТЕРСО-Токиогийн Эрчим Хүчний Компани өөрсдийн реле хамгаалалт, автоматикийн ИТА, монтёруудын мэдлэгийн шалгалтын материалуудтай танилцан, ажилтнуудад тавигдах үндсэн 3 шатны шаардлагад нийцсэн зэрэглэл тогтоох шалгалтын тестийг боловсруулахаар ажиллаж байна.

Мөн эдгээр үндсэн зорилт, ажлуудаас гадна Монгол Улсын эрчим хүчний системд тулгарч байгаа болон шинээр нэвтэрч байгаа технологи, мөрдөгдөж байгаа стандартууд зэрэг асуудлуудаар туршлага судалж, Япон улсын эрчим хүчний системд хэрхэн шийдсэн талаар мэдээллүүдийг авч салбаруудын инженер, техникийн ажилтнуудад мэдээлэл өгч ажиллаж байна.

Япон улсын эрчим хүчний систем нь ашиглагдаж байгаа тоног төхөөрөмж, цаг уур, эрчим хүчний хэрэглээ зэрэг Монгол улсын эрчим хүчний системээс ялгаатай талууд байгаа боловч одоогийн хурдацтай явагдаж байгаа шилжилтийн үе, технологийн шинэчлэл зэрэг дээр үнэтэй мэдээллүүдийг авч байгаа нь үр дүнгээ өгч байна.

**SWG-6 дэд ажлын хэсгийн тайлан**

Жайкай олон улсын байгууллагаас хэрэгжүүлж байгаа "Сэргээгдэх эрчим хүчний оролцоо ихтэй эрчим хүчний системийн тогтвортой байдлыг нэмэгдүүлэх, чадавхыг бэхжүүлэх төсөл"-ийн хүрээнд SW6 дэд ажлын хэсэг буюу дэд станцын ажлын хэсэгт 2022 оны 06 дугаар сараас цахим байдлаар анх хамтарч ажилласан.

Сургалтын гол зорилго нь дэд станцын үндсэн тоноглолын үзлэг, үйлчилгээ хийх гарын авлагыг Монгол Улсад мөрдөгдөж байгаа хууль, дүрмийн хүрээнд боловсруулахад оршино.

ТЕПКО компанийн сургагч багш нар манай компани дээр танхимаар болон Япон улсаас цахим байдлаар сургалтыг зохион байгуулж байгаа.

SW6 ажлын хэсгийн ахлагчаар ЦДҮС ТӨХК-ийн Төв удирдлагын ЗЗТХ-ийн засвар төлөвлөлт, судалгааны инженер Д.Доржпүрэв, гишүүдэд ЗЗТХ-ийн хүчний трансформаторын засварын инженер Д.Баттулга, РХАХТХ-ийн цахилгаан хэмжлийн лабораторын эрхлэгч Ж.Хосбаяр, өндөр хүчдэлийн туршилтын инженер Б.Лут-Эрдэнэ, Улаанбаатар салбарын инженерийн албаны засварын инженер Д.Нэмэхбаяр, Засварын албаны ахлах бөгөөд засварын инженер В.Батбаяр нар багаар ажилласан.

Үндсэн тоноглолын хүрээнд хүчний трансформатор, хийн таслуур, хийн хуваарилах байгууламж, вакум таслуур, хэмжүүрийн трансформатор, оруулга, газардуулга зэрэг тоноглолын үзлэг, үйлчилгээний гарын авлага боловсруулж байна.

Үзлэг үйлчилгээний гарын авлагат хамрах хүрээ, хариуцах албадын үүрэг, үзлэгийн төрөл, хугацаа, гарч болох гэмтэл, доголдлын талаар болон цаашид авах арга хэмжээг тодотгон оруулж байгаа болно. Одоогийн байдлаар гарын авлагын явц 70 орчим хувийн гүйцэтгэлтэй байгаа ба сургагч багш нарт 2024 оны 04 дүгээр сарын 01-ээс 09-ний хооронд ирэх үед хянуулж зөвлөгөө авч ажиллаж байна.



Мөн тус төслийн хүрээнд холбогдох хүмүүс Япон улсад туршлага судлах, шинэ техник технологитой танилцаж судлан, боломжтой шийдлийг хэрэгжүүлэх зорилгоор ажилласан.

**Япон улсад ажилласан талаар:**

1. Ибараки муж дахь "ТЕРСО" PG-н салбар станц болох 275/66/22 кВ-ын станцын ойролцоо агаарын шугамын утасны төлөвийг дроноор үзлэг хийх талаар танилцуулга болон үзүүлэн сургалтад оролцсон. Дроноор үзлэг хийхдээ төмөр тулгуурын нэг фазын эхлэлээс шугамын утсаа таниулж дуусаад дрон нь автоматаар өөрөө утсаа дагаад үзлэг хийх ба дэлгэцээр тусдаа үзлэгийг хянах мөн бичлэгийг цуглуулж дууссаны дараа анализ хийж ажиллах боломжтой. Дрон нь 30 минут үзлэг хийх чадалтай.




2. Хитачи хот дахь "SUMITOMO ELECTRIC INDUSTRIES" LTD дамжуулах утасны үйлдвэртэй танилцсан. Тус үйлдвэр нь Оюутолгой-Цагаансуварга чиглэлийн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын дамжуулах чадвар өндөртэй утсыг нийлүүлсэн үйлдвэр байсан. Тус үйлдвэр нь дамжуулагч утсанд цас, мөстөлт, дуу чимээний зэрэг олон шинэ технологи нэвтрүүлж байгааг үзэж танилцсан. Дуу чимээний туршилт хийхдээ хиймлээр салхины хүчийг 40 м/с хүртэл үүсгэж туршилт хийж байгаа нь шинэлэг байв. Мөн дамжуулагчийн таталтын хүчний туршилтыг хийж дамжуулагчийг хэдэн кН хүчээр татахад тасрач гэмтэж байгааг харсан. Гол нь эдгээр туршилтыг хийж байхдаа зураг, бичлэг хийлгээгүй.




3. Шин-Тоёсу 500/275/66/22 кВ-ын газар доорх дэд станцтай танилцсан. Дэлхийд анх удаа 500 кВ-ын 40км урттай кабель шугамтай станц гэж танилцуулсан. 1км тутамд кабель шугамын холболтын хайрцаг байдаг. 2000 оны 11-р сард анх ашиглалтад орсон. 2013 оноос хүнгүй дэд станц болсон.




4. Дамжуулах сүлжээний операторын төв TEPCO PC's NOV-overview очиж танилцсан. Дэд станцаас ирж байгаа мэдээллийг хүлээн авч сүлжээний шуурхай зохицуулалт хийж ажилладаг. Тус төвийн барилга 101 метр өндөртэй ба барилгын дээр 100 метр өндөр цамхаг антена байрлуулж бусад цамхагуудтай холбогдож мэдээлэл солилцдог.




5. Гунма муж, Нумато хот, Танбара усан цэнэгт цахилгаан станцтай танилсан. 1982 онд байгуулагдсан хүнгүй станц юм. Танбара станц нь 1982 онд Нумата хот ба Минаками хотын хооронд өндрийн зөрүүг ашиглах зорилгоор баригдсан дээд тал нь 1.2 сая кВт-ын хүчин чадалтай шахуургатай цахилгаан станц юм. Дээд усан сан нь Нумата хотын Хочигава голын эхэнд баригдсан Танбара далан (чулуу дүүргэсэн далан, 116 м өндөр) бөгөөд доод усан санд Минаками хотын Фүживара нуурыг ашигладаг. Үр дүнтэй уналт нь 518 м, нийт шахуургын өндөр нь 559 м бөгөөд энэ нь дэлхийн хамгийн том далангийн нэг юм. Энэ газар нь Жошинэцу Коген үндэсний цэцэрлэгт хүрээлэнтэй зэргэлдээ, Окутоне аялал жуулчлалын бүсэд оршдог тул байгаль хамгаалахад нэн тэргүүнд анхаарч цахилгаан станцыг газар доор барьсан.
6. 275/154/66 кВ-ын Кото дэд станцтай очиж танилцсан. Хаалттай хуваарилах байгууламж. Нэг фазын хүчний трансформаторуудтай станц.




7. "Канденко" өндөр хүчдэлийн лаборатортай танилцсан. Лаборатort 66 кВ-ын кабельд аянгын импульс хүчдэл тэсвэрлэх туршилтыг сонирхсон.
8. Shizuoka муж, Нумазу хотын Мэйдэншэ группийн үйлдвэртэй очиж танилсан. 1897 онд байгуулагдсан үндсэн оффис нь Токио, Осакад байдаг. Тус үйлдвэрийн хүчний трансформатор, 66 кВ-ын таслуур, 22 кВ-ын ячейк, микропроцессорын релейний төхөөрөмжүүд үйлдвэрлэдэг хэсгүүдтэй танилцаж мэдээлэл авсан.
9. ТЕПКО сургалтын төвтэй танилцсан нь нийт хүмүүст ихээр таалагдсан. ТЕПКО компанид анх ажилд орж байгаа хүмүүс тус сургалтын төвөөр дамжиж зэрэглэлээ тогтоодог ба зэрэг ахихдаа болон өөр ажлын байранд шилжихэд мөн тус сургалтын төвөөр дамжин эрх авдаг.

Дамжуулах утасны засвар, гэмтэлийг хэрхэн засах талаар сургалт дадлагыг бодитоор болон вертуал орчинд өндөр хүчдэлийн тулгуурын оройн хэсэгт ажил гүйцэтгэж байгаа хүмүүсийн хөдөлгөөн, өөрөө мөн өндрөөс харж байгаа мэдрэмж зэрэг үйлдэлтэй танилцсан.

Релейний шалгалт тохируулга, GIS-н таслуур, хуваарилах байгууламж зүсэлт хийсэн модель, мөн сургалтын зориулалттай хүчний трансформаторт зохиомлоор гэмтэл үүсгэж хэмжилт хийн дүгнэлт гаргах зэрэг сургалтын бааз суурь, материалыг үзсэн.





Япон улсад SWG-4, SWG-5, SWG-6 дэд ажлын хэсгийн нийт 17 хүн, 1 орчуулагчийн бүрэлдэхүүнтэй 2024 оны 02 дугаар сарын 25-ны өдрөөс 2024 оны 03 дугаар сарын 08-ны өдрийг хүртэл ажлын 10 өдөр хамрагдсан ба нийт хүмүүст Жайкай байгууллагаас сертификат гардуулсан.



**Төслийн SWG-3 ажлын хэсгийн тайлан**

Төслийн сургалтад дараах агуулгуудыг багтаан төслийг хэрэгжүүлж байна Үүнд:

1. Сүлжээний симулятор (DIgSILENT компанийн PowerFactory)-ыг ашиглан сүлжээний төрөл бүрийн тооцоолол, шинжилгээ хийхэд суралцана.
2. Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор эрчим хүчний эх үүсвэрийн дунд болон урт хугацааны төлөвлөлтийн хувилбаруудыг судална.
3. Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэхтэй уялдуулан дунд болон урт хугацааны сүлжээ төлөвлөлтийн хувилбаруудад (эх үүсвэр төлөвлөлтийн хувилбарууд болон эрэлтийн таамаглалд тулгуурлан дамжуулах шугам, дэд станцуудынөргөтгөлгөх мэт) дүн шинжилгээ хийхэд энэхүү программ хангамжийг ашиглана.
4. Дунд болон урт хугацааны сүлжээг тогтворжуулах арга хэмжээг авч үзэх (холын зайн дамжуулалт болон сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэхэд сүлжээг тогтвортой байлгах арга хэмжээг оролцуулан).
5. PowerFactory програмын сэдвүүд дээр цаашид ашиглах гарын авлага боловсруулах, сургагч багшийг бэлдэх

Төслийн хүрээнд сургалтыг Монголд буюу ЦДҮС ТӨХК дээр гурван удаа, JAICA олон улсын байгууллагаас гаргасан хөтөлбөрийн дагуу Япон улсад нэг удаа зохион байгуулаад байна. Төслийн сургалтыг дотор гурван (Групп-А,В,С) хэсэг болон зохион байгуулсан нь компаниас олон инженерүүдийг хамруулах боломжтой болсон.

Групп-А /РХА/,
Д.Өлзийсайхан /УБС-ын РХАХТА-ны дарга/
Ц.Мөнхтөр /ГБС-ын РХАХТА-ны РХА-н инженер/
Б.Тунгалагсайхан /ТУ, РХАХТХ-н автоматикийн тооцооны инженер
Н.Ичинхорлоо /УБС-ын РХАХТА-ны РХА-н монтёр/
Групп-В /Транк системийн төлөвлөлтийн ажилтан/,
Б.Золбаяр /УБС-ын горим тооцооны инженер/
Л.Оюунномин /ХБС-ын горим, баланс тооцоо, хэмнэлтийн инженер/
Э.Байгалмаа /ТБС-ын ИХ-н хэмнэлт, горимын инженер/
Д.Баяржаргал /ЗӨБС-ын ИХ-н горим, баланс тооцоо, хэмнэлтийн инженер/
М.Сувд /ГБС-ын ИХ-н горим, тооцооны инженер/
Групп-С /Ахисан түвшин/
Б.Амарбаясгалан /ТУ, ТБТХ-н горим тооцооны инженер/
Ц.Номинзаяа /ТУ, ТБТХ-н системийн тооцооны инженер/
Б.Тунгалагсайхан /ТУ, РХАХТХ-н автоматикийн тооцооны инженер/

Мөн Компанийн хэмжээнд POWER FACTOR-2018 хувилбар ашиглан тооцоо судалгаа хийж байсаныг төслийн хүрээнд POWER FACTOR-2023 болгон шинэчлэлт хийгдсэн нь үр дүнтэй ажил болсон.



2023 оны 11 сарын 12-ноос 11 сарын 25-ны хооронд SWG-1 болон SWG-3 багийн гишүүд Япон улсад сургалтад хамрагдлаа. Төслийн багийн гишүүд.



Сургалтын хугацаанд очиж танилцсан ЭХС-ийн байгууллагууд болон сургалтын сэдвүүд:

1. TEPCO PG Диспетчерийн төв, TEPCO PG Диспетчерийн Канагавагийн төв, Япон орны цахилгаан эрчим хүчний үйл ажиллагааны танилцуулга
2. OCCTO (Organization for Cross-regional Coordination of Transmission Operators, Japan)

Цахилгаан эрчим хүч дамжуулах операторуудын бүс дамнасан зохицуулалтын байгууллага

3. Шинэ тоёосу дэд станц
4. Дараагий үеийн хяналт мэдээллийн хэрэгсэл SCADA
5. Имайчи усан цахилгаан станц. Ус хуримтлуурын цахилгаан станц




Тус дэд станц нь уулын гүнд газар доор байрласан 1050 MW хүчин чадалтай хоёр далангийн хоорондын зай 524 м бөгөөд 1979 онд анх барьж эхэлсэн түүхтэй. Доорх зураг 500 kV -ын кабелийн гаргалгааг үзүүлсэн байна.

6. Ёкохама хотын өмчит Каназава үйлдвэр (хог хаягдлыг шатаах ба цах илгаан эрчим хүчийг үйлдвэрлэх байгууламж)
7. Чигасаки судалгааны төв (RTDS симулятор)
8. Тошиба, Аккумулятор, дэд станцийн симулятор, кибер аюулгүй байдал

# “НЭГЭН ЖАРНЫ ТҮҮХ” БУЛАН

***ТАЙЛБАР:** Монгол Улсад цахилгаан дамжуулах сүлжээ үүсэж хөгжсөний нэгэн жарны түүхэн ой 4 жилийн дараа тохиох болно. Түүхийн үйл явцтай холбогдуулан Дамжуулах сүлжээ сонинд “НЭГЭН ЖАРНЫ ТҮҮХ” буланг Ахмадын хорооноос шинээр нээж техникийн дэвшил, түүнийг эзэмшигч хөдөлмөрийн хүмүүсийн тухай цувралаар нийтэлж байна. Бид өмнөх дугаартаа Говийн бүсийн салбарын түүхэн товчооныг нийтэлсэн бол энэ дугаартаа Улаанбаатар салбарын түүхэн товчооныг хүргэж байна.*

## УЛААНБААТАР САЛБАРЫН ОН ДАРААЛЛЫН ТОВЧООН (ЦУВРАЛ-7)

**2012 он**

Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2012 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 05 дугаар тогтоол, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2012 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 10 дугаар тогтоолоор “Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ” ТӨХК-ийн нэрийг “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” гэж өөрчилж, компанийн бүтцийг шинэчилж, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2012 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 20 дугаар тогтоолоор Улаанбаатар салбарыг шинээр Улаанбаатар хотод байгуулж, анхны Улаанбаатар салбарын даргаар Б.Дашдаваа, ерөнхий инженерээр Х.Алтанхуяг нар томилогдсон. Компанийн гүйцэтгэх захирлын 2012 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн Б/225 дугаар тушаалаар Улаанбаатар салбарын даргаар Х.Алтанхуяг даргаар, Я.Мөнхтөр ерөнхий инженерээр томилогдсон.

Монгол Улсад анх удаа Дархан Улаанбаатар хотыг холбосон 110 кВ-ын 114,115,116,117 дугаар транзит агаарын шугамын хамгаалалтыг орчин үеийн микропроцессорын хамгаалалтаар иж бүрэн сольсон.

Хайлааст дэд станцын хүчин чадлыг өргөтгөж, Туул дэд станцаас 25 МВА чадалтай 2 ком трансформаторыг зөөж, суурилуулсан.

Налайх Салхин паркийн 110 кВ-ын ЦДАШ-ын тулгуур дугаарлах газардуулга хийх, утасны унжилт тохируулах, тулгуур №1-4 хооронд тулгуур босгох, утас татах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

220/110/35 кВ-ын Улаанбаатар, 110/35/10 кВ-ын Дорнод-2 дэд станцуудын 110 кВ-ын тоноглолуудын хоёрдогч хэлхээний хяналтын кабелийг бүрэн сольж шинэчилсэн.

Улаанбаатар хотын 110 кВ-ын тойрог схемийн найдвартай ажиллагааг хангах зорилгоор 109,110 дугаар ЦДАШ-ын реле хамгаалалт автоматикийн байгууламжийг шинэчилж, сүүлийн үеийн микропроцессорын баазтай хамгаалалтаар сольсон.

Компанийн 2012 оны “Шилдэг ажилтан”-аар Улаанбаатар салбарын үйлчлэгч Б.Цэенхүү, Улаанбаатар салбарын “Тэргүүний ажилтан”-аар хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн инженер Ш.Чулуунсүрэн нар шалгарсан.

**2013 он**

110 кВ-ын 101,102-р агаарын шугамын тулгуур №45-ыг анкер тулгуураар, 220 кВ-ын 203,204-р шугамын тулгуур №57-г хүчитгэсэн анкер тулгуураар, Ил хуваарилах байгууламж-3-д 110 кВ-ын Тойруу систем шинийн ПМ-4,5 маягийн 320 ширхэг шаазан хөндийрүүлэгчийг ПС-70 маягийн шилэн хөндийрүүлэгчээр тус тус сольсон.

Цэвэрлэх, Налайх, Яармаг дэд станцуудад цахилгаан механик РЧ релег микропроцессорын релегээр шинэчилсэн.

Улаанбаатар, ИХБ-3, ИХБ-4, Дорнод-2 дэд станцуудад Тойт-ын хамгаалалтыг микропроцессорын хамгаалалттай болгосон.

Баруун дэд станцын 10 кВ-ын хуваарилах байгууламжийг иж бүрэн шинэчилсэн.

110/35/10 кВ-ын Сэлбэ дэд станцын 110 кВ-ын ил хуваарилах байгууламжийг нүүлгэн шилжүүлсэн.

110/35/10 кВ-ын Өмнөд дэд станцын 25 МВА чадалтай хүчний трансформаторыг БНХАУ-д үйлдвэрт нь засварлуулж, хүчдэлд залгав.

110 кВ-ын Баянмөнх-Өндөрхаан цахилгаан дамжуулах агаарын шугам болон Зүүн-Өмнөд бүсийн салбарын Бор-Өндөр-Өндөрхааны 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамд байгалийн давтагдашгүй хүчин зүйлийн улмаас гарсан ааварийг богино хугацаанд устгах ажилд ур чадвар гарган ажилласан.

Их тойрог төслөөр 220 кВ-ын 99 км цахилгаан дамжуулах агаарын шугам, 110 кВ-ын 200 км цахилгаан дамжуулах агаарын шугам, 220 кВ-ын 1, 110 кВ-ын 6 дэд станц баригдаж, 2014 онд дуусгахаар ажиллаж байна.

110/10 кВ-ын Хөшигт дэд станц, Налайх-Хөшигтийн цахилгаан дамжуулах агаарын шугамын барилга угсралтын ажлыг гүйцэтгэж, ажилд залгасан.

220 кВ-ын агаарын шугам 208, ШОВ-2-ын реле хамгаалалт автоматикийг орчин үеийн микропроцессорын реле хамгаалалтаар шинэчлэн сольж, тоноглолын дэргэд реле хамгаалалтыг анх удаа байрлуулсан нь хяналтын кабелийг байхгүй болгож, хамгаалалтын найдвартай ажиллагааг дээшлүүлсэн дэвшил болсон.

Компанийн гүйцэтгэх захирлын 2013 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн Б/160 дугаар тушаалаар ерөнхий инженерээр Д.Ганзориг томилогдсон.

Компаниас зарласан өндөр бүтээлийн уралдаанд “Шилдэг хэлтэс, алба”-аар Улаанбаатар салбарын Засварын алба шалгарсан.

“Ажлын байрны соёл-5С” хөтөлбөрийг хэрэгжүүлж, 110/35/10 кВ-ын Дорнод-2 дэд станц 2 дугаар байр эзэлсэн.

Компанийн 2013 оны “Хөдөлмөрийн аварга засварын монтёр”-оор Улаанбаатар салбарын Засварын албаны засварын монтёр Б.Оргил, “Хөдөлмөрийн аварга албан хаагч”-аар Улаанбаатар салбарын ашиглалт, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн О.Уранчимэг нар шалгарав. Улаанбаатар салбарын “Тэргүүний ажилтан”-аар Засварын албаны дарга С.Ариунбат шалгарсан.

**2014 он**

Ил хуваарилах байгууламж-4-ийн 220 кВ-ын 7-р блокийн өргөтгөл шинэчлэлийн ажлыг гүйцэтгэсэн. Шинэчлэлтийн ажил бүрэн хийж дуусаж ашиглалтад орсноор Монгол Улсын цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл 500 сая кВт. цагаар нэмэгдсэн.

Гудамж төслийн Дүнжингарав худалдааны төвөөс Улиастайн гүүр хүртэлх 6 км автозамын трасст орсон 103,104 дүгээр агаарын шугамын бетон тулгуур №22,23-г У110-2+5 өндөрлөсөн анкер тулгуураар сольсон.

110/10/6 кВ-ын Өмнөд дэд станцад 2x63 МВА-ийн чадалтай трансформатор сольж суурилуулсан. Ингэснээр Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн цахилгаан эрчим хүч хэрэглэгчдийн эрчим хүчний тасралтгүй, найдвартай ажиллагааг бүрэн хангаж, бүтээн байгуулалтын томоохон ажил болсон.

220 кВ-ын 203, 204-р агаарын шугамын тулгуур №1-67 хооронд ADSS маягийн шилэн кабель татах ажлыг хийж гүйцэтгэсэн.

Налайх дэд станцын 35 кВ-ын Элстэй-Б вакум таслуурыг элегаз таслуураар сольсон.

ИХБ-3,4, Улаанбаатар, Дорнод-2 дэд станцын ТойТ-ын реле хамгаалалт автоматикийг шинэчилсэн.

110 кВ-ын Ил хуваарилах байгууламж-3-ын 35 кВ-ын Холбоо А,Б шугамын МКП маркийн тосон таслуурыг элегаз таслуураар шинэчилсэн.

Улаанбаатар хотын зүүн хэсгийн дулааны эрчим хүчний хангамжийг сайжруулах зорилгоор баригдсан Амгалан дулааны станцыг 110 кВ-ын цахилгаан эрчим хүчээр тэжээх 110/10 кВ-ын Амгалан дэд станцын өргөтгөлийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэж, хүчдэлд залгав.

Ил хуваарилах байгууламж-2 ба 3-ыг холбосон 35 кВ-ын Холбоо А,Б шугамын толгойн талд 4 ком вакум таслуурыг шинээр суурилуулан анхдагч холболтуудыг хийснээс гадна өндөр технологи бүхий реле хамгаалалт автоматикийн байгууламжийг иж бүрнээр нь шинэчлэн суурилуулав. Уг ажлыг гүйцэтгэснээр эрчим хүчний эх үүсвэр болох ДЦС-3, ДЦС-2 ТӨХК-ийн найдвартай ажиллагааг дээшлүүлж, систем үүсгэгч шугамын тасралтгүй байдал сайжирсан.

Улаанбаатар салбарыг өөрийн конторын байр, автомашины гараж, засварын цехтэй болгож, конторын барилгын гадна, дотор тохижилтын ажлыг гүйцэтгэж ашиглалтад оруулсан.

Реле хамгаалалт автоматик болон хэмжүүр, тоолуурын сургалтын панелийг угсарч ашиглалтад оруулсан.

Шинээр 6 автомашины гараж барьж, халаалт, дотор цахилгаан монтажийн ажлыг бүрэн хийж гүйцэтгэсэн.

Салбарын нэгдүгээр давхарт байсан аж ахуйн складыг буулгаж, засвар үйлчилгээ хийж, архивын өрөөтэй болсон.

Компанийн аж ахуйн хашааг 2 хувааж, тусгаарлан шинээр 80 метр хашаа барьж, 6 метр хаалга гарган, салбар өөрийн аж ахуйн хашаатай болсон.

Реле хамгаалалт, автоматикийн чиглэлээр инженер Б.Лхагвадэмбэрэл Арабын нэгдсэн Эмират улсад баригдаж буй шинэ дэд станцын угсралтын ажилд урилгаар оролцож туршлага солилцсон.

Компанийн гүйцэтгэх захирлын 2014 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн Б/124 дүгээр тушаалаар салбарын даргаар Д.Ганзориг, компанийн гүйцэтгэх захирлын 2014 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн Б/125 дугаар тушаалаар Д.Жаавай ерөнхий инженерээр томилогдсон.

“Ажлын байрны соёл-5С” хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлсэн “Оны шилдэг дэд станц”-аар Улаанбаатар салбарын Үйлдвэр дэд станц 2 дугаар байрт, Сэлбэ дэд станц 3 дугаар байрт шалгарав.

Компанийн 2014 оны “Хөдөлмөрийн аварга шуурхай ажиллагааны инженер техникийн ажилтан”-аар Улаанбаатар салбарын диспетчер инженер Б.Батчулуун, “Хөдөлмөрийн аварга албан хаагч”-аар Улаанбаатар салбарын автын механик Б.Мөнхжаргал, Улаанбаатар салбарын “Тэргүүний ажилтан”-аар Засварын албаны засварын монтёр В.Батбаяр нар шалгарсан.

**2015 он**

110/35/10 кВ-ын ИХБ-3-т 20 мВа хүчний трансформаторыг 40 мВа чадалтай трансформатороор өөрийн хөрөнгөөр сольж суурилуулснаар систем үүсгэгч гол зангилаа дэд станцын найдвартай ажиллагааг хангагдсан.

Их тойрог-110 кВ-ын бүтээн байгуулалтаар хийгдэж дууссан 40 гаруй км урт цахилгаан дамжуулах агаарын шугам, “7-р хороолол”, “Радио телевиз”, “Найрамдал” дэд станцуудыг хүчдэл дор тавьж ачаалал өгсөн. Энэ ажил хийгдсэнээр Улаанбаатар хотын хойд болон зүүн хойд хэсгийн хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг бүрэн хангах боломжтой болсон.

220/110/35 кВ-ын Улаанбаатар дэд станцын 110 кВ-ын шинийн хамгаалалтын шинэчлэлтийг хийсэн. Тус компанийн Реле хамгаалалт, туршилт хэмжүүрийн хэлтэс, Улаанбаатар салбарын Реле хамгаалалт, хэмжүүр, туршилтын алба хамтран схем шийдэл, тавил тохируулга, угсралт монтажийн ажлыг хийж, амжилттай ажилд залгасан.

Монгол инженерүүдийн гараар хийгдсэн төв дохиоллын төхөөрөмж нь Улаанбаатар салбарын Реле хамгаалалт, хэмжүүр, туршилтын албаны бүтээл бөгөөд тус төхөөрөмж нь 36 оролттой, GSM сүлжээ ашиглан мэдээлэл дамжуулдаг, хуучин төв дохиоллын хэлхээнд шууд уялдан ажиллах боломжтой бөгөөд олон улсын “MODBUS” протоколоор “HMI” системтэй холбогдох боломжтойгоор хийгдсэнээр онцлог юм.

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн анхны алсын удирдлага, хяналт бүхий дэд станц. Тус дэд станцыг Улаанбаатар салбарын диспетчерийн өрөөнөөс удирдаж хянах, мөн дэд станцын “HMI” системээс удирдах боломжтойгоор хийгдсэн юм.

110/35/10 кВ-ын Залаат дэд станцын “SEIMENS” үйлдвэрийн 110/35/10 кВ хүчний трансформаторыг Монголд анх удаа засварласан онцлог ажил болсон.

Транзит 110 кВ-ын 2 хэлхээ шугамтай У110-2 маркийн анкерийг солих ажлыг гүйцэтгэхдээ хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр таслахгүй, найдвартай ажиллагааг хангах зорилгоор нэмэлт тулгуур босгож түр тэжээлээр хангасан ба гэмтсэн тулгуурыг буулгаж шинэ тулгуурыг угсарч хэвийн схемд оруулсан. Энэхүү ажлыг их засварын хүрээнд богино хугацаанд аюул осол, тасралт сааталгүй хийсэн ба цаашид учрах аюул ослоос урьдчилан сэргийлж чадсан.

110/35/10 кВ-ын “Налайх” дэд станцын хуучин 35 кВ-ын “7-р зэрлэг” цахилгаан дамжуулах агаарын шугамыг 110 кВ-д шилжүүлэх ажил хийгдсэн. Энэ ажлын хүрээнд Багахангай дүүрэгт шинээр баригдах 110/35/10 кВ-ын 16 мВа чадалтай Өндөртолгой дэд станцыг хүлээн авч ашиглалтыг хариуцан ажиллаж байна.

Улаанбаатар салбарыг төв удирдлагын сүлжээнд холбосноор Digsilent-ийн сервертэй холбогдох боломж бүрдсэн. Мөн Улаанбаатар салбарт SCADA системийг амжилттай ажиллуулсан.

Компанийн гүйцэтгэх захирлын 2015 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн Б/51 дүгээр тушаалаар салбарын даргаар Д.Балдорж томилогдсон.

Компанийн 2015 оны “Хөдөлмөрийн аварга албан хаагч”-аар Улаанбаатар салбарын хангамжийн мэргэжилтэн Л.Намнандорж, Улаанбаатар салбарын Ашиглалтын албаны ээлжийн техникч Ш.Цогтбаатар нар шалгарсан.

**2016 он**

Улаанбаатар хотын цахилгаан хэрэглээний өсөлт нэмэгдсэнтэй холбоотойгоор Ил хуваарилах байгууламж-3-ын хүчний трансформаторын чадлыг нэмэгдүүлэн иж бүрэн шинэчилж ашиглалтад оруулсан.

Улаанбаатар хотын 9 дэд станцын газардуулгын эсэргүүцэл сайжруулах ажлыг хөндлөн электродын аргачлалаар тооцон гүйцэтгэж, ашиглалтын найдвартай ажиллагааг хангасан.

220 кВ-ын 2, 110 кВ-ын 8 дэд станцыг шинээр барьсан. 110 кВ-ын 7-р хороолол, Телевиз, Найрамдал, Буянт ухаа, 14-р хороолол, Зайсан дэд станцууд сүлжээнд залгагдсан. “14-р хороолол”, “Зайсан” дэд станцыг ашиглалтад оруулсан.

Умард дэд станцад шинээр суурилуулсан Резистор-1,2-г ажилд залгахтай холбоотойгоор 10 кВ-ын 28 фидерт тэг дарааллын гүйдлийн трансформатор суурилуулан МП-ын реленүүдэд газардлагын хамгаалалтын тавилыг тавих ажлыг гүйцэтгэсэн.

ЦДАШ 111,112-д шилэн кабель бүхий аянгын тросс татах ажлыг гүйцэтгэсэн. Энэ ажлын үр дүнд ИХБ-3, ИХБ-4 гадны байгууллагаас хараат бусаар 48 сувгийн шилэн кабелиар өндөр хурдны интернэт, харилцаа холбоо, шугамын реле хамгаалалтын найдвартай хангагдсан.

Яармаг дэд станцын 35 кВ-ын Зуунмод-Б фидерийн С-35-630-10Б У1 маягийн тосон таслуурыг ZW7-40.5 маркийн вакуум таслуураар солих угсралтын ажлыг гүйцэтгэсэн

ИХБ-4-н 220 кВ-ын 5 ком хуурай салгуурыг шинэчлэх ажлын хүрээнд бүх хоёрдогч хэлхээний кабелийг шинээр сольж, хуурай салгуурыг алсын удирдлагын төхөөрөмжөөр тоноглох хэмжээний угсралтын ажлыг хийсэн.

Их тойрог 110 кВ-ын сүлжээний 110/35/10 кВ-ын 14-р хороолол дэд станц /2016.11.04-ний өдөр хүчдэлд залгасан/, 110/35/10 кВ-ын “Зайсан” дэд станц /2016.12.22-ний өдөр хүчдэлд залгасан/ шинээр ашиглалтад орсон.

Дамжуулах сүлжээний үйл ажиллагааг сайжруулах, шуурхай үйл ажиллагааг цахимжуулах чиглэлээр “Дамжуулах сүлжээний удирдлага мэдээллийн систем” /ДСУМС/-ийн 1-р хувилбарыг дуусгаж, Төв удирдлага, Улаанбаатар салбарт нэвтрүүлсэн.

*Мэдээллийг бэлтгэсэн:*
*УБС-ын ЗААА-ны ахлах бөгөөд дотоод ажил хариуцсан мэргэжилтэн Т.Аюуш*

**Үргэлжлэлийг дараагийн дугаарт**

***Эрхлэн гаргасан: Захиргаа удирдлагын хэлтсийн хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах мэргэжилтэн Д.Энхбаяр***